Мөн компанийн зүгээс 0,5 литртэй усыг ажилчид өөрсдийн хэрэгцээгээрээ дураараа авч ашигладаг байсан юм энэ нь усыг дутуу ууж орхих, усанд хайр гамгүй үрэлгэн хандаж байна гэж үзээд байгаль орчны мэргэжилтэнгүүдийн санаачилгаар 0,5 литртэй усыг өгөхгүйгээр ажилчдад усны сав тарааж өгч баллонтой усыг ус авч болох бүх цэгүүд дээр байршуулсан. Ингэснээр усыг зөв зохистой өөрсдийн хэрэглээндээ тааруулж ашиглаж байгаа гэж үзэж байгаа.



Зураг 5. Баллантай усыг байршуулсан байдал, ажилчидад тарааж өгсөн усны савнууд

4.5 Олон салаа зам гаргаж хөрс талхлагдахаас сэргийлж зааварчилгаа өгч бүртгэл хөтлөх

Орон нутгийн замаар зорчих ажилчдад олон зам үүсгэхээс урьдчилан сэргийлж Ноён сум, Гурвантэс, Өмнөговь аймгийн чиглэлд явахдаа уурхайн бүсээс гараад тогтсон маршрутаар явах талаарх зааварчилгааг өгч бүртгэл хөтлөх ажлыг Пост-4 дээр хамгаалагч нараар хийлгэж байна. 2024 оны 3-р улирлын байдлаар 150 гаруй удаагийн зорчин хөдөлгөөнд зааварчилгаа өгч гарын үсэг зуруулж ажилласан юм. Орон нутгийн чиглэлд зөвхөн уурхайн ажилчдаас гадна нүүрс тээврийн жолооч нарийн жижиг тэрэгнүүд, орон нутгийн иргэд мөн манай уурхайгаас үл хамаарсан Гурвантэсээс Өмнөговь аймгийн чиглэлийн зорчих хөдөлгөөн нь уурхай орчмын олон салаа зам үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна. Иймээс бид 2024 онд Ноён сумын засаг даргатай ярилцан Ноён – Хар сэрвэгэн – Гурвантэс- Өмнөговь аймгийн чиглэлд явах хөдөлгөөний маршрутыг тодорхойлон бусад хэсгээр зорчих хэсгүүдээр замын хаалт, чиглэлийг тодорхойлсон самбаруудыг байршуулсан. Замын хаалт давж зорчсон хэсгүүдэд дор бүрд хаалтыг сэргээж аль болох олон салаа зам үүсгэхгүй байх тал дээр онцгой анхаарч ажилласаар байна. Орон нутаг руу тээврийн хэрэгслээр зорчих хөдөлгөөн хийж зааварчилгаа авсан ажилчдын бүртгэлийг тайланд хавсаргав.



Зураг 6. Замын хаалт хийж чиглэл тодорхойлсон самбар байршуулсан байдал



Зураг 7. Зорчих хөдөлгөөнийг ногоон зураасыг дагуу тодорхойлж, зам дагуу тренч татсан юм



Зураг 8. Олон салаа зам үүссэн хэсэгийг хамгаалснаар байгалын аясаар зам бүдгэрч нөхөн сэргэх аяс явагдсан байдал

4.6 Хөрс бохирдуулагч хөрсөнд алдагдсан тохиолдолд саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээ авах

ШТС-ын талбайн асгаралтад ашиглах техникийн сода, засварын байранд асгаралтын иж бүрдэл, үртэс зэргийг ашиглан саармагжуулалд хийж байна. Мөн ШТС, Засварын байрны цемент дээр тос масло, түлш асгарсан тохиолдолд “spill kit”, үртэс ашиглах, хөрсөн дээр асгаралт үүссэн тохиолдолд техникийн сода, элс ашиглан саармагжуулах ажлыг хийж байна. Хар сэрвэгэн төслийн талбай дээр ямар нэгэн засварын талбай дэд бүтцийн барилга байгууламж байхгүй тул асгаралт бүртгэгдээгүй юм. Мөн жижиг хэмжээний асгаралтуудыг тухай үед нь саармагжуулж, цэвэрлэж ажилласан.



Зураг 9. Жижиг асгаралтуудын саармагжуулж буй байдал

4.7 ШТМ шингээгч, цэвэрлэх материалын хангамж


Хар сэрвэгэн төслийн талбай дээр ямар нэгэн засварын талбай дэд бүтцийн барилга байгууламж байхгүй ШТС, Засварын талбай нэг юм. Иймээс асгаралтын иж бүрдлийг Цагаан Өвөлжөө ХХК-тай хамтад бэлтгэсэн юм. Шатахуун түгээгүүрийн талбайд асгаралтад ашиглах тос масло шингээгч, цэвэрлэх материал “spill kit”-ын хангаж ажилаж байна. 2024 онд нийт 10 уут техникийн сода 20 уут модны үртэс мөн 4 ширхэг асгаралтын иж бүрдлийг худалдан авалт хийгдэж Засварын газар болон Шатахуун түгээгүүрийн асгаралтын эрсдэл өндөр 2 байршилд байршуулж ажилсан. Ихэнх засварын ажлууд шопын байранд хийгддэг учир гадна талбайн асгаралд харьцангуй бага байдаг .



Зураг 10. Шатахуун түгээгүүр болон засварын газар асгаралтын иж бүрдлийг байршуулсан байдал

4.8 Эвдэрсэн газрын бүртгэл

Хөндөгдсөн талбайн бүртгэлийг хөтлөх ажлуудыг өмнөх жилүүдийн адилаар үргэлжлүүлэн бүртгэж жилийн эцсийн тайлангуудад тайлагнаж байна. 2024 онд нийт 15 га талбайг 5 удаагийн газар хөндөх зөвшөөрлийн маягт бөглөж газар хөндөж ашигласан байна. Газар хөндөх зөвшөөрлийн тухай бүрд маркшейдэртэй хамт бөглөж явж байна.



Зураг 11. Хар сэргээгн ордын 2024 онд шинээр хөндөгдсөн талбайн мэдээлэл

Хүснэгт 6. Эвдэрсэн газрын нийт хэмжээ, 2024 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар


Licence - MV_19149			
	Location	Disturbed Area (ha)	Date of Clearing Work
	JTD Cumulative at end of previous period	149.65	30/06/2024
	Current period summary		
1	Pit - 6	15	30/09/2024
2			
3			
	Period Total		
	JTD Cumulative at end of current period	149.65	

Surveyor : C. Нэгмэлт

Senior engineer: А. Огьорзул

4.9 Уурхайн тэлэлтийн явцад олборлолт эхлэхээс өмнө шинээр технологийн зам тавих

2024 онд шинээр технологийн 1 зам тавьсан ба газар хөндөх зөвшөөрлийн маягтыг бөглөж 2,7 га талбайг хамарсан замаас 68м³ шимт хөрсийг хуулж шимт хөрсний техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд байршуулсан юм.



Зураг 12. Уурхайд шинээр зам тавьсан технологийн бүдүүвч зураг

4.10 Өмнөх жилүүдэд тарьсан модны усалгааг тогтмол гүйцэтгэх

Сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд уурхайн орчимд тарьсан модны арчилгаа усалгааг тогтсон хуваарь гаргаж услах ажлыг үргэлжлүүлэн хийсээр байна. Модны усалгааг хуваарийн дагуу тогтмол кемпийн модыг 3 хоногтоо нэг удаа, уурхайн үүдний хэсэгт тарьсан модыг 2 хоногт 1 удаа, биологийн нөхөн сэргээлтийн талбай болон модыг өдөр бүр хуваарийн дагуу 4-10 сарын хооронд хийсээр байна. 2022, 2023 онд уурхай орчимд тарьсан 500 гаруй сухай, хайлаас модны ургалт 95%-тай ургалтын өндөр 1 метрээс 2 метрт хүртэл болсон байна. 2022 онд хийсэн 3,6 га биологийн нөхөн сэргээлтийн усалгаа арчилгааг 3 дахь жилдээ хийж ажиллаа. Биологийн нөхөн сэргээлтийн талбайд ургасан ургамлын зүйлийн бүрдэл нэмэгдэж хөмүүл, таана зэрэг ургамлууд олноороо ургасан юм. Кемпийн баруун талд нөхөн тарилтаар тарьсан 100 хайлаас өмнөх жилүүдийн тарьсан модод бүгд тогтмол усалснаас ургалтад сайнаар нөлөөлсөн. 2024 оны хувьд хур бороо элбэг байсан нь модны өсөлтөд сайн нөлөө үзүүллээ. 2024 оны 09 дүгээр сарын байдлаар **18880** м³ усыг ногоон байгууламжийн усалгаанд зарцуулсан байна. Усалгааг 04 дүгээр сарын эхнээс эхэлж хийсэн бөгөөд ногоон байгууламжийн усалгаанд намираа болон дуслын усалгааны аргыг хэрэглэснээс ус зарцуулалт маш багассан юм.



Зураг 13. Өмнөх жилүүдэд хийгдсэн ногоон байгууламжийн ургалтын байдал



Зураг 14. 2023 болон 2024 оны модны ургалтын байдлыг харьцуулав.



Зураг 15. 2022 онд хийсэн биологийн нөхөн сэргээлтийн усалгаа арчилгааг 3 дах жилдээ хийж ажиллаж байна

4.11 Смарт дата хэрэгжүүлэх


Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хамтарсан багийн санхүүжилтийг төлөвлөгөөнд тусган Өмнөговь аймгийн Байгаль орчныг хамгаалах санд төвлөрүүлэн ажилласан билээ.



Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: 246204720

Татсан огноо: 2024-03-25 09:11

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
3635124134 MN020015003635124134	100110051407	5,134,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр ЭНХТУНХ ОРЧЛОН	Хүлээн авагчийн нэр ӨМ.БОРЧНЫГ ХАМГААЛАХ САН	Гүйлгээний утга ЭНХТУНХ ОРЧЛОН ХХК 5618339	
	Хүлээн авагчийн банк Төрийн сан	Гүйлгээний огноо 2024-03-22	
Гүйлгээг шивсэн хэрэглэгч	Гүйлгээг хянасан хэрэглэгч	Гүйлгээг баталсан хэрэглэгч	
ш. түвшинзаяа	с. баасанхүү	с. баасанхүү 	

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

Зураг 16. Төлбөрийн баримт

5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлтийн хураангуй

№	Нөхөн сэргээлтийн төрөл	Нөхөн сэргээсэн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Биелэлт
1	Шимт хөрс хуулах	Хөрсний үржил шимт хөрсий үеийг хуулах	га	70 га	2024 оны 09-р сарын 30-ны байдлаар эвдрэлд орсон нийт 15 га талбайгаас 8453 га үржил шимт хөрс хуулах, хадгалах ажил хийгдсэн. Шимт хөрсийг нийт шинээр талбайд хадгалаж байна. Дэлгэрэнгүйг тайлангийн 5.1 Үржил шимт хөрс хуулалт, хадгалалт дэд бүлэгт оруулав.

5.1 Үржил шимт хөрс хуулалт, хадгалалт

2024 оны уулын ажлын төлөвлөгөөнд нийт 70 га талбай уурхайн үйл ажиллагаанд өртөхөөр тусгагдсан. 2023 онд 09 дүгээр сарын 30-ний гүйцэтгэлээр нийт 15 га талбай уурхайн олборлолт тэлэлтэд өртөж **8453** м3 шимт хөрсийг хуулан хадгалаад байна. 2024 онд хуулсан шимт хөрснийг шинээр шимт хөрсний овоолго үүсгэн хадгалаад байна.



Зураг 17. Пит-6 тэлэлтээс гарсан шимт хөрсийг хуулж хадгалсан байдал

6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3-р зүйлийн 3.1.11-д "биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах" гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах, түүний ойролцоох газрын судалгааг хийх арга хэмжээг хэлнэ гэж тодорхойлсон байдаг. MV-017162 болон MV-019149 тоот тусгай зөвшөөрлийн талбайн орчимд биологийн олон янз байдлын судалгаа шинжилгээг 2018 онд мэргэжлийн байгууллага болох “Нээхийн мандал” ХХК-аар гүйцэтгүүлсэн. 2022 онд Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хөтөлбөрийг мэргэжлийн байгууллага болох “Их монголын байгаль” ХХК хийлгэж 2024 онд тухайн төлөвлөгөөний хүрээнд 2 дах жилийн судалгааны ажлыг хийж хэрэгжүүлсэн.

Хүснэгт 8. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө биелэлтийн хураангуй

№	Хэргэжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлт
1	Бэлчээрийн менежмент зохион байгуулж байгаа талбайг хамгаалахын тулд / машины зам, эвдрэл, бохирдол/ “Энэ талбайд бэлчээрийн менежментийн арга хэмжээ явуулж байна” гэсэн утгатай пайз сэргээх дахин хийх.	Ноёны нуруу	4	Төсөл хариуцагч	Бэлчээрийн менежментийн цэгт “Энэ талбайд бэлчээрийн менежментийн арга хэмжээ явуулж байна” гэсэн утгатай өмнөх онд хийсэн самбар алга болсон тул 4 цэг дээр самбаруудыг дахин хийж байршуулав. Дэлгэрэнгүй мэдээллийг 6.1 дэд бүлэгт оруулав.
2	Ургамалжлын судалгааны мониторингийн цэгийг сэргээх	Ноёны нуруу	4	Төсөл хариуцагч	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэх хамгаалах ажлын хүрээнд Ноёны нуруу дагуу бэлчээрийн төлөв байдлыг судлах зорилгоор урт хугацааны мониторингийн 6 цэг байгуулж ажилласан. Тус цэгүүдийг сэргээн 2 дах жилийн судалгааг үргэлжлүүлэн хийв. Дэлгэрэнгүй зурган мэдээллийг 6.2-г.

3	<p>Бэлчээрийн мониторинг цэг бүрд 5,6,7,8,9,10-р саруудад дараах үзүүлэлтүүдээр судалгаа хийх</p> <ul style="list-style-type: none"> -Зүйлийн бүрдлийн өөрчлөлт -Бэлчээрийн ургамалжлын бүрхцийн өөрчлөлт -Бэлчээрийн ургацын өөрчлөлт 	Ноёны нуруу	6	Төсөл хариуцагч	<p>2023 онд Биологийн олон янз байдлыг дүйцүүлэх хамгаалах ажлын хүрээнд Ноёны нуруу дагуу бэлчээрийн төлөв байдлыг судлах зорилгоор урт хугацааны мониторингийн 6 цэг байгуулсан. Тухайн цэгүүдэд 2024 онд 5, 6, 7, 8, 9, 10 саруудад ургамлын зүйлийн бүрдлийн шинж чанарын судалгааг үргэлжлүүлэн хийж ажиллалаа. Зүйлийн бүрдэл, ургамлын бичиглэлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг 6.3-дэд бүлэгт оруулав.</p>
4	Хөдөлгөөн мэдрэгч бүхий камераар амьтаны мониторинг судалгааг хийх	Ноёны нуруу	Тогтсон цэгүүдэд	Төсөл хариуцагч	<p>Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хөтөлбөрийн хүрээнд 5 жилийн хугацаанд нийт 20 цэг дээр хөдөлгөөн мэдрэгч бүхий камераар амьтны мониторинг судалгааг хийх ажлын 2023 онд 10 байршилд хийсэн билээ. Энэ онд 2023 оны 6 байршилд шинээр 4 байршил гээд нийт 10 байршил дээр үргэлжлүүлэн амьтны мониторинг судалгааг хийсэн юм. Энэ тухай мэдээллийг 6.4 дэд бүлэгт дэлгэрэнгүй оруулав.</p>
5	Хөдөлгөөн мэдрэгч бүхий камер худалдан авах	Уурхайд	2 ширхэг	Төсөл хариуцагч	<p>2023 онд Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд хөдөлгөөн мэдрэгч бүхий 2 камерыг Ноён сумын байгаль хамгаалагчаас авч ашиглаж байсан юм. Тиймээс энэ онд шинээр хөдөлгөөн мэдрэгч бүхий 2 камерыг худалдан авч судалгааг хийлээ. Энэ тухай мэдээллийг 6.5 хэсэгт оруулав.</p>
6	Ган зудтай үед шаардлагатай газруудад биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Ноёны нуруу	1	Төсөл хариуцагч	<p>2024 оны 04 дүгээр сард Биотехникийн арга хэмжээнд Ноён сумын Байгаль хамгаалагч болон Идэвхтэн байгаль хамгаалагч нар, компанийн байгаль орчны мэргэжилтэн, ажилчид хамтран Ноён сумын амьтадын байрлаж нутагладаг 10 цэгт 250 боодол өвсийг байршуулан Биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлээ. Дэлгэрэнгүй мэдээллийг 6.6-ийн биотехникийн арга хэмжээ дэд бүлэгт оруулав.</p>

6.1 Энэ талбайд бэлчээрийн менежментийн арга хэмжээ явуулж гэсэн утга бүхий пайзыг сэргээн засварлах

Бэлчээрийн менежментийн цэгт “энд бэлчээрийн төлөв байдлын судалгааны цэг” гэсэн утгатай өмнөх онд хийсэн самбар алга болсон тул 4 цэг дээр самбаруудыг дахин хийж байршуулав. Тухайн самбарыг байршуулснаар аль болох судалгааны цэг дайруулан малаа бэлчээхгүй байх талаар зарим судалгааны цэгт ойр малчинд мэдээлэл өгсөн юм.



Зураг 18. Судалгааны цэгийн орчимд самбарыг байршуулж буй байдал

6.2 Ургамалжлын судалгааны мониторингийн цэгийг сэргээх

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэх хамгаалах ажлын хүрээнд Ноёны нуруу дагуу бэлчээрийн төлөв байдлыг судлах зорилгоор урт хугацааны мониторингийн 6 цэгийг 2023 онд байгуулж ажилласан. Тус цэгүүдийг сэргээн 2 дах жилийн судалгааг үргэлжлүүлэн хийв. /судалгааны цэгүүдийг дахин хаягжуулах, чулууг будах, хүрээг сэргээх зэрэг/



Зураг 19. Бэлчээрийн төлөв байдлын судалгааны цэгүүдийн байршил



Зураг 20. Бэлчээрийн төлөв байдлын судалгааны цэгүүдийг сэргээн засварлаж, хэмжээлт хийж буй байдал /5-р сард/

6.3 Бэлчээрийн төлөв байдлын мониторинг судалгаа

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэх хамгаалах ажлын хүрээнд Ноёны нуруу дагуу бэлчээрийн төлөв байдлыг судлах зорилгоор урт хугацааны мониторингийн 6 цэгийг 2023 онд байгуулж тухайн цэгүүдэд 2024 оны 5, 6, 7,8,9,10 саруудад ургамлын зүйлийн бүрдлийн шинж чанарын судалгааг үргэжлүүлэн хийж ажиллалаа. Энэ онд хур тунадас элбэгтэй байсан нь ургамлын зүйлийн бүрдэл, ургамлын ургалт ихээр нэмэгдсэн юм. Судалгааны цэгүүдээр тэсэг, хазаар өвс, таана, хөмүүл, сахилдаг, усан хамхуул, бортууз, бор бударгана, дэрс, харгана, баглуур, буйлс зэрэг ургамлууд зонхилон ургасан. Судалгааны цэгүүдийн 80-90 орчим хувь нь ургамлын бүрхэцтэй зэргээс тодорхойлогдож байгаа юм.

Хүснэгт 9. Судалгааны цэгүүдийн ерөнхий мэдээлэл

№	Судалгааны цэг	Ургамлын судалгааны газрын байршил /Координат/	Судалгааны хугацаа	Бэлчээрийн төлөв байдлын судалгааны цэгүүдийн гол зонхилох ургамал
1	Судалгааны цэг-1	N=43° 10' 7.09 ^{II} E=102° 17' 33.57 ^{II}	5, 6, 7, 8, 9, 10 сар	Тэсэг, хазаар, таана, хөмүүл, сахилдаг, усан хамхуул, бортууз, бор бударгана
2	Судалгааны цэг-2	N=43° 8' 06.73 ^{II} E=102° 20' 12.73 ^{II}	5, 6, 7, 8, 9, 10 сар	Таана, хөмүүл, бударгана, бортууз, усан хамхуул
3	Судалгааны цэг-3	N=43° 6' 34.02 ^{II} E=102° 9' 13.70 ^{II}	5, 6, 7, 8, 9, 10 сар	Тэсэг, хазаар, таана, хөмүүл, сахилдаг, усан хамхуул, бортууз, бор бударгана
4	Судалгааны цэг-4	N=43° 1' 41.88 ^{II} E=102° 33' 13.70 ^{II}	5, 6, 7, 8, 9, 10 сар	Хамхуулнууд, бударгана, харгана, монгол өвс, шарилж, таана, хөмүүл
5	Судалгааны цэг-5	N=43° 10' 33.78 ^{II} E=102° 02' 38.35 ^{II}	5, 6, 7, 8, 9, 10 сар	Усан хамхуул, бударгана, харгана, монгол өвс, таана
6	Судалгааны цэг-6	N=43° 12' 32.75 ^{II} E=101° 51' 44.56 ^{II}	5, 6, 7, 8, 9, 10 сар	Таана, монгол өвс, хөмүүл, хазаар өвс, тэсэг

Ургамлын мониторинг судалгаанд даргаар аргуудыг хэрэглэлээ.

- Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн тодорхойлох
- Ургамлын бүрхэц /Халцгай, хад чулууны бүрхэц/
- Ургацын өндөр /ургалт/ сар бүрээр тодорхойлох

Хүснэгт 10. Судалгааны цэг – 1 бэлчээрийн төлөв байдлын сар бүрийн судалгааны үр дүн

Бэлчээрийн хэв шинж Судалгааны цэг-1	Үзүүлэлт								
	Ургамлын бүрхэц %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Ургамлын талхагдлын бүрхэц %	Халцгай газрын хэмжээ %	Хад чулууны хэмжээ %	Хагдны хэмжээ %	Ургац өндөр см	
	1м ² талбайд	1м ² талбайд	10м ² талбайд					ургамал /бага/	ургамал /өндөр/
5 дугаар сар	40	4	6	40	30	30	0	8	10
6 дугаар сар	40	4	6	45	25	30	0	4	15
7 дугаар сар	50	6	9	80	10	10	0	2	25
8 дугаар сар	60	6	10	80	10	10	0	6	30
9 дүгээр сар	45	5	7	80	10	10	0	6	26
Дундаж	47	5	10	65	17	18	0	5.2	21.2




График 6. Судалгааны цэг – 1 ургамлын тархацын мэдээлэл /10м²/



Зураг 21. Судалгааны цэг-1 дээр ажиллаж буй нь /8-р сар/

Хүснэгт 11. Судалгааны цэг – 2 бэлчээрийн төлөв байдлын сар бүрийн судалгааны үр дүн

Бэлчээрийн хэв шинж Судалгааны цэг-2	Үзүүлэлт								
	Ургамлын бүрхэц %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Ургамлын талхагдлын бүрхэц %	Халцгай газрын хэмжээ %	Хад чулууны хэмжээ %	Хагдны хэмжээ %	Ургамлын өндөр /см/	
		1м ² талбайд	1м ² талбайд					10м ² талбайд	ургамал /бага/
5 дугаар сар	50	4	6	50	25	25	0	8	15
6 дугаар сар	50	4	6	60	25	15	0	8	20
7 дугаар сар	55	5	6	80	10	10	0	13	23
8 дугаар сар	60	6	6	80	10	10	0	6	22
9 дүгээр сар	65	5	7	80	10	10	0	4	22
Дундаж	56	4.8	6.2	56	30	14	0	7.8	20.4




График 7. Судалгааны цэг – 2 ургамлын тархацын мэдээлэл /10м²/



Зураг 22. Судалгааны цэг-2 дээр ажиллаж буй нь /7-р сар/

Хүснэгт 12. Судалгааны цэг – 3 бэлчээрийн төлөв байдлын сар бүрийн судалгааны үр дүн

Бэлчээрийн хэв шинж Судалгааны цэг-3	Үзүүлэлт								
	Ургамлын бүрхэц % 1м ² талбайд	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Ургамлын талхагдлын бүрхэц %	Халцгай газрын хэмжээ %	Хад чулууны хэмжээ %	Хагдны хэмжээ %	Ургамлын өндөр /см/	
		1м ² талбайд	10м ² талбайд					ургамал /бага/	ургамал /өндөр/
5 дугаар сар	20	3	3	30	35	25	0	8	12
6 дугаар сар	10	2	4	40	50	10	0	5	15
7 дугаар сар	20	4	5	50	40	10	0	13	23
8 дугаар сар	40	5	6	60	30	10	0	7	18
9 дүгээр сар	50	5	7	70	15	15	0	3	18
Дундаж	28	3.8	5	50	34	14	0	7.2	17.2




График 8. Судалгааны цэг – 3 ургамлын тархацын мэдээлэл /10м²/



Зураг 23. Судалгааны цэг-3 дээр ажиллаж буй нь /6-р сар/

Хүснэгт 13. Судалгааны цэг – 4 бэлчээрийн төлөв байдлын сар бүрийн судалгааны үр дүн

Бэлчээрийн хэв шинж Судалгааны цэг-4	Үзүүлэлт								
	Ургамлын бүрхэц % 1м ² талбайд	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Ургамлын талхагдлын бүрхэц %	Халцгай газрын хэмжээ %	Хад чулууны хэмжээ %	Хагдны хэмжээ %	Ургамлын өндөр /см/	
		1м ² талбайд	10м ² талбайд					ургамал /бага/	ургамал /өндөр/
5 дугаар сар	20	3	4	40	50	10	0	3	15
6 дугаар сар	20	2	4	45	45	10	0	3	15
7 дугаар сар	40	5	6	70	15	15	0	11	17
8 дугаар сар	60	5	8	85	10	5	0	6	60
9 дугаар сар	60	5	8	60	30	10	0	6	18
Дундаж	40	4.0	6	60	30	10	0	5.8	25



График 9. Судалгааны цэг – 4 ургамлын тархацын мэдээлэл /10м²/



Зураг 24. Судалгааны цэг-4 дээр ажиллаж буй нь /5-р сар/

Хүснэгт 14. Судалгааны цэг – 5 бэлчээрийн төлөв байдлын сар бүрийн судалгааны үр дүн

Бэлчээрийн хэв шинж Судалгааны цэг-5	Үзүүлэлт								
	Ургамлын бүрхэц % 1м ² талбайд	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Ургамлын талхагдлын бүрхэц %	Халцгай газрын хэмжээ %	Хад чулууны хэмжээ %	Хагдны хэмжээ %	Ургамлын өндөр /см/	
		1м ² талбайд	10м ² талбайд					ургамал /бага/	ургамал /өндөр/
5 дугаар сар	20	3	6	60	20	20	0	6	20
6 дугаар сар	25	3	6	50	30	20	0	5	30
7 дугаар сар	30	3	7	50	20	30	0	10	22
8 дугаар сар	90	6	9	90	5	5	0	17	80
9 дүгээр сар	80	4	5	80	10	10	0	11	30
Дундаж	49	3.8	6.6	66	17	17	0	9.8	36.4



График 10. Судалгааны цэг – 5 ургамлын тархацын мэдээлэл /10м²/



Зураг 25. Судалгааны цэг-6 дээр ажиллаж буй нь /9-р сар/

Хүснэгт 14. Судалгааны цэг – 6 бэлчээрийн төлөв байдлын сар бүрийн судалгааны үр дүн

Бэлчээрийн хэв шинж Судалгааны цэг-6	Үзүүлэлт								
	Ургамлын бүрхэц % 1м ² талбайд	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Ургамлын талхагдлын бүрхэц %	Халцгай газрын хэмжээ %	Хад чулууны хэмжээ %	Хагдны хэмжээ %	Ургамлын өндөр /см/	
		1м ² талбайд	10м ² талбайд					ургамал /бага/	ургамал /өндөр/
5 дугаар сар	30	3	4	50	25	25	0	5	10
6 дугаар сар	20	4	6	40	30	20	0	2	17
7 дугаар сар	40	5	6	60	20	20	0	11	18
8 дугаар сар	80	4	6	80	20	0	0	11	37
9 дүгээр сар	70	4	6	80	10	10	0	11	30
Дундаж	48	4.0	5.6	62	21	15	0	8	22.4





График 11. Судалгааны цэг – 6 ургамлын тархацын мэдээлэл /10м²/



Зураг 26. Судалгааны цэг-6 дээр ажиллаж буй нь /8-р сар/


СУДАЛГААНЫ ЦЭГ - 1 /10M²/



Ургамлын талхагдлын бүрхэц % Халцгай газрын хэмжээ % Хад чулууны хэмжээ % Ургамал бага Ургамал өдөр

— 2023 — 2024


СУДАЛГААНЫ ЦЭГ - 2 /10M²/



Ургамлын талхагдлын бүрхэц % Халцгай газрын хэмжээ % Хад чулууны хэмжээ % Ургамал бага Ургамал өдөр

— 2023 — 2024


СУДАЛГААНЫ ЦЭГ - 3 /10M²/



Ургамлын талхагдлын бүрхэц % Халцгай газрын хэмжээ % Хад чулууны хэмжээ % Ургамал бага Ургамал өдөр

— 2023 — 2024

СУДАЛГААНЫ ЦЭГ - 4 /10M²/



Ургамлын талхагдлын бүрхэц % Халцгай газрын хэмжээ % Хад чулууны хэмжээ % Ургамал бага Ургамал өдөр

— 2023 — 2024

График 8. Судалгааны цэг 1, 2, 3, 4-р цэгүүдийн мэдээллийг 2023, 2024 оныг харьцуулсан байдал




График 9. Судалгааны цэг 5, 6-р цэгүүдийн мэдээллийг 2023, 2024 оныг харьцуулсан байдал

6.4 Хөдөлгөөн мэдрэгч бүхий камераар амьтаны мониторинг судалгааг хийх

2022 онд “Их монголын байгаль” ХХК-аар хийлгэсэн Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд Ноёны нурууны дагуух тогтсон цэгүүдэд хөдөлгөөн мэдрэгч бүхий камераар амьтны мониторинг судалгааг хийхээр зааж өгсөн билээ. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хөтөлбөрийн хүрээнд 5 жилийн хугацаанд нийт 20 цэг дээр хөдөлгөөн мэдрэгч бүхий камераар амьтны мониторинг судалгааг хийх ажлын 2023 онд 10 байршилд хийсэн билээ. Энэ онд 2023 оны 6 байршилд шинээр 4 байршил гээд нийт 10 байршил дээр үргэлжлүүлэн амьтны мониторинг судалгааг хийсэн юм. Судалгааны камерт энэ жил ямар нэгэн амьтан үнэг, туулай, хярс зэрэг давхардсан тоогоор 12 амьтан бүртгэсэн байгаа юм. Зарим амьтад камерт ойрхон байснаас дүрс нь мэдэгдэхгүй зургууд ихэнх нь байна.



Зураг 27. Камерт бичигдсэн үнэг, туулай



○ 19°C 66°F 2023/08/02 06:28:58



● 17°C 62°F 2023/05/01 10:06:16



● 25°C 77°F 2023/04/21 00:26:34



○ 24°C 75°F 2023/08/03 07:46:26




● 24°C 75°F 2023/07/28 00:15:46



● 26°C 78°F 2023/05/01 09:59:07

Зураг 28. Хяналтын камерт орсон хар сүүлт



Зураг 29. Амьтны судалгааны автомат камер суурьлуулсан газрын байршил

Хүснэгт 15. Хяналтын камерт бичигдсэн амьтадын мэдээлэл

№	Газрын нэр	Байршил координат	Хугацаа /хоног/	Хяналтын камерт орсон амьтадын тоо	Хяналтын камерт орсон амьтад
1	Харганан	N=43°10'44.72 ^{II} E=102°10'35.12 ^{II}	30	0	-
2	Шинэ ус	N=43°09'36.15 ^{II} E=102°11'31.81 ^{II}	30	2	Үнэг, хэрээ
3	Ар задгай урд хэсэг	N=43°08'47.61 ^{II} E=102°15'39.70 ^{II}	25	5	Хар сүүлт
4	Өвөр задгай баруун ар	N=43°08'01.27 ^{II} E=102°15'27.10 ^{II}	25	1	Туулай
5	Хөгшин хайрханы ар	N=43°07'22.33 ^{II} E=102°21'09.58 ^{II}	30	1	Туулай
6	Хөгшин хайрханы өвөр	N=43°06'30.72 ^{II} E=102°21'11.65 ^{II}	30	1	Туулай
7	Ямаатын ар	N=43°08'56.90 ^{II} E=102°29'06.51 ^{II}	30	1	Шувуу
8	Ханын хүрэн	N=43°07'35.15 ^{II} E=102°32'00.34 ^{II}	30	0	-
9	Шинэ усны урд хяр	N=43°05'36.31 ^{II} E=102°09'27.40 ^{II}	28	0	-
10	Даравгайн хярын ард	N=43°04'12.98 ^{II} E=102°09'43.00 ^{II}	28	1	Хэрээ
Хяналтын камерт орсон нийт				12	



Зураг 30. . Камер байршуулж буй байдал

6.5 Хөдөлгөөн мэдрэгч бүхий камер худалдан авах

2023 онд Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд хөдөлгөөн мэдрэгч бүхий 2 камерыг Ноён сумын байгаль хамгаалагчаас авч ашиглаж байсан юм. Тиймээс энэ онд шинээр хөдөлгөөн мэдрэгч бүхий 2 камерыг худалдан авч судалгааг үргэлжлүүлэн хийлээ.



Зураг 31. Хөдөлгөөн мэдрэгч бүхий шинээр худалдан авсан камерууд

6.6 Биотехникийн арга хэмжээ

Жил бүр цаг үеийн байдлаас шалтгаалан болзошгүй аюул, эрсдэлээс зэрлэг амьтадаа хамгаалах, хорогдол гаргахгүй байх зорилгоор нэн ховор, ховор амьтад нутагладаг өвөлжилт, хаваржилт хүндэрсэн газруудад өвс, тэжээл тавьж биотехникийн арга хэмжээ авч ажилладаг. 2024 оны 04 дүгээр сард биотехникийн арга хэмжээнд Ноён сумын Байгаль хамгаалагч болон Идэвхитэн байгаль хамгаалагч нар, компанийн байгаль орчны мэргэжилтэн, ажилчид хамтран Ноён сумын Ганзагад багийн Уужим, Жигдэн, Бөөн тоорой, Янгиртын рашаан, Баруун зүүн сахилдагтай, Сайран багийн Сүвт, Бүлээний задгай, Зост булаг, Сүмбэрийн булаг, Хайлаастайн булаг зэрэг Аргал, Янгир Хар сүүлт амьтадын байрлаж нутагладаг 11 цэгт 250 боодол өвсийг байршуулан Биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Цаашид биотехникийн арга хэмжээг төлөвлөгөөний дагуу шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлж ажилласаар байх юм.



Зураг 32. Биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлсэн байдал

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Энхтунх Орчлон ХХК-ын Хар сэрвэгэн нүүрсний төслийн хүрээнд уурхайн нөлөөллийн бүсийг тогтоож, нөлөөлөлд өртөх айл өрхүүдийн судалгааг гаргасны үндсэн дээр айлуудыг нүүлгэн шилжүүлж, нөхөн олговрыг бүрэн олгосон. Иймээс 2024 онд энэ чиглэлийн ажил төлөвлөгдөөгүй болно.

Уурхайн үйл ажиллагаанаас болж нийгэм эдийн засагт дараах хэд хэдэн төрлийн нөлөөлөл үүсэж болзошгүй юм.

- *Олон нийтийн эрүүл мэндийн болон аюулгүй байдал:*
- *Малын бэлчээрийн талбай багасах:*
- *Малчид болон нутгийн оршин суугчид, зарим хэрэглэгчдийн эрх ашиг хөндөгдөх*

Ийм учир нөлөөллийн бүсийн оршин суугчдын эрх ашгийг бодож нөхөн олговрыг бүрэн олгож дууссан.

8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн тусгай зөвшөөрөл бүхий талбайд 2012-2013 онуудад археологи палеонтологийн хайгуул судалгааны ажлыг эрдэм шинжилгээний байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлсэн бөгөөд уурхайн талбайд нийт 16 дурсгал тодорхойлогдсоныг **авран хамгаалах ажлыг** Шинжлэх Ухааны Академийн Түүх Археологийн хүрээлэнгийн эрдэмтэд судлаачидтай хамтран гүйцэтгэсэн. Төслийн талбайд 2013 оноос өнөөг хүртэл үйл ажиллагаа явуулж ирэхэд ямар нэгэн нэмэлт түүхийн дурсгал илрээгүй байна.

Хүснэгт 16. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний мэдээлэл

№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Биелэлт
1	Археологи болон палеонтологийн дурсгал	Хэрэв олборлолтын явцад шинээр түүх соёлын дурсгал илэрвэл авран хамгаалах арга хэмжээ зохион байгуулах	Жилийн турш	2024 онд үйл ажиллагаа явуулахад ямар нэгэн авран хамгаалах шаардлага гараагүй.

9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Энхтунх Орчлон” ХХК-ийн хувьд “Цагаан Өвөлжөө” ХХК-тай хамт химийн бодисыг үйл ажиллагаандаа хэрэглэхдээ гэрээт компани болох “Спешиал Майнинг Сервисес” ХХК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр уурхайн тэсэлгээний үйлчилгээг хийлгэж байна. Энэ гэрээний нөхцөл нь уг ажил үйлчилгээг үзүүлэгч аж ахуйн нэгжүүд нь тусгай зөвшөөрлийнхөө хүрээнд өөрийн бараа материал (химийн бодис болон тэсрэх бодис), хүн хүчийг ашиглан ажил үйлчилгээг гүйцэтгэх бөгөөд уг ажил үйлчилгээг гүйцэтгэсний нийт төлбөрийг манай компаниас гаргуулахад оршино. Иймд уг үйлчилгээнүүдийг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд нь химийн бодисын ашиглалт, хадгалалт, тээвэрлэлт, зайлуулалтай холбоотой холбогдох үүрэг хариуцлагыг бүрэн хүлээдэг бөгөөд бид химийн бодисын хэрэглээний бүртгэл, хог хаягдлын тээвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Уурхайн лабораторид 2 төрлийн бодис ашиглаж байгаа бөгөөд хэрэглээ маш бага ба хаягдал үүсдэггүй өндөр градууст нүүрстэй хамт шатдаг.

Хүснэгт 17. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн хураангуй

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ авах	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх давтамж	Биелэлт
1	Химийн бодисийн хэрэглээнд хөндлөгийн хяналт тавих	Төслийн хүрээнд	12 бүртгэл	Сар бүр	Спешиал Майнинг Сервисес ХХК гэрээт байгууллагуудын химийн болон аюултай бодис хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт дээр уурхайн үйл ажиллагааны явцад тогтмол хяналт тавьж ажиллалаа. Дэлгэрэнгүйг 9.1 химийн хорт болон аюултай бодис хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтын бүртгэл дэд бүлэгт оруулав.
2	Осол, аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулах	Төслийн хүрээнд	1 төлөвлөгөө	Жилд нэг удаа	2024 онд Осол, аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг Налайх дүүрэгт байрлах Уул уурхайн авран ангиар батлуулж төлөвлөгөөний дагуу ажилсан. 9.2 төлөвлөгөөний батлагдсан нүүрийг дэд бүлэгт оруулав.
3	Болзошгүй аюул ослын үед нөхцөл байдлыг холбогдох байгуулагад мэдээлэх, шаардлагатай үед нэмэлт дайчилгаа зохион байгуулах	Төслийн хүрээнд	Тодорхойгүй	Шаардлагатай үед	2024 оны хувьд ямар нэгэн байдлаар гал түймэр болон олныг хамарсан бусад аюул осол бүртгэгдээгүй юм.

9.1 Химийн хорт болон аюултай бодис хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтын бүртгэл

Уурхайн лабораторит ашиглах химийн бодисуудыг тухайн сард төлөвлөсөн хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр ашигладаг. Химийн бодисын хаягдлыг хамгийн бага байхаар /маш багаар/ хэрэглэдэг. Нүүрс шинжилгээний лабораторид хэрэглэдэг химийн бодисуудын нэг сарын хэрэглээний хэмжээ нь дараах байдалтай байдаг. Үүнд:

- *Бензойний хүчил сард 50 -120 грам,*
- *Магнийн перхлоратыг /чийг шингээгчээр/ /одоогоор ашиглахгүй байгаа/*
- *Савангийн уусмал нь 250- 500 грам*

Шинжилгээнд ашигласан химийн бодисууд хаягдал бараг үүсэхгүй өндөр градуст шатаж нүүрстэй урвалд ордог. Химийн бодисыг ашиглах, хадгалах явцад хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх. Лаборатори нь дэгдэмхий ууршимтгай болон хамт хадгалах хориотой бодисууд ашигладаггүй болно. Бодис тус бүрийг хадгалалтын стандарт шаардлага хангасан кабинетад дараах байдлаар хадгалдаг.

- *Бензойны хүчлийг илчлэг тодорхойлох өрөөний хадгалах шүүгээнд дангаар*
- *Магнийн перхлоратыг зориулалтын хуванцар саванд хүхэр тодорхойлох өрөөнд дангаар тус тус хадгалдаг.*

Лабораторийн бодисыг хэрэгцээнээс илүү хэмжээгээр өөр зориулалтаар ил задгай хэрэглэхгүй байх зарчмыг баримталдаг.



Зураг 33. Химийн бодисыг хадгалаж буй байдал



Уурхай дээрх лабораторид ашиглагдах химийн бодисуудыг тухайн сард ашиглах маш бага хэмжээгээр бага багаар хэрэглэдэг. Дараах хүснэгтээс 2023 онд хэрэглэсэн лабораторийн бодисуудын хэрэглээний сар тутмын бүртгэлийг харна уу.

Хүснэгт 18. Лабораторын бодисын сар бүрийн хэрэглээний бүртгэл

Урвалжийн нэр	Савангийн уусмал		Бензойны хүчил		Магнийн Перхлорат		Бүртгэл хийсэн огноо	Хэрэглээний бүртгэл мэдээлэл өгсөн лабораторийн ахлах ажилтан	Хянасан байгаль орчны ажилтан
	Химийн томьёо	$C_{58}H_{118}O_{24}$		$C_7H_6O_2$		$Mg(ClO_4)_2$			
Зориулалт	Нүүрсний бодит нягт тодорхойлох шинжилгээнд норгогч уусмалаар хэрэглэгддэг.		Нүүрсний илчлэг тодорхойлох шинжилгээнд сертификатжсан стандарт загвар болгон хэрэглэгддэг.		Нүүрсний нийт хүхэр тодорхойлох шинжилгээнд чийг шингээгчээр ашиглагддаг.				
	Хэмжих нэгж /кг/		Хэмжих нэгж /кг/		Хэмжих нэгж /кг/				
2024 он	Хүлээн авсан	Хэрэглэсэн	Хүлээн авсан	Хэрэглэсэн	Хүлээн авсан	Хэрэглэсэн			
1 сар	9 кг	500 гр	1500 г	120 гр			2024.01	Д.Түвш	У.Баяр
2 сар	8,5 кг	500 гр	1480 г	120 гр			2024.02	Д.Түвш	Хангаар
3 сар	8 кг	500 гр	1360 г	120 гр			2024.03	Д.Түвш	У.Баяр
4 сар	7,5 кг	500 гр	1240 г	120 гр			2024.04	Д.Түвш	У.Баяр
5 сар	7 кг	500 гр	1120 г	120 гр			2024.05	Д.Түвш	Хангаар
6 сар	6,5 кг	500 гр	1000 г	120 гр			2024.06	Д.Түвш	У.Баяр
7 сар	6 кг	500 гр	880 г	120 гр			2024.07	Д.Түвш	У.Баяр
8 сар	5,5 кг	500 гр	750 г	150 г			2024.08	Д.Түвш	У.Баяр
9 сар	5 кг	500 гр	—	150 гр			2024.09	Д.Түвш	У.Баяр
10 сар									
11 сар									
12 сар									
Жилийн нийт хэрэглээ									


“Спейшил Майнинг Сервисес” ХХК тэсэлгээнд ашиглагдах химийн бодисуудыг тухайн сард ашиглах хэмжээгээр бага багаар хэрэглэдэг. Тэсэлгээний бодисын сав баглаа боодол хаягдлыг өөрсдийн химийн бодисын хаягдал хадгалах цэгт хуримтлуулан хадгалдаг. Уурхайн талбай дээр химийн бодисын үлдэгдэл хаягдал устгах ажлыг гүйцэтгэдэггүй бөгөөд тэсэлгээний бодис ачиж ирсэн зориулалтын техникт ачиж явж өөрсдийн зөвшөөрөгдсөн цэгт устгалд оруулдаг юм. 2024 онд байгаль орчны ажлын байрны үзлэгээр бодисын сав баглаа боодлыг ихээр хуримтлуулах хот руу ачуулахгүй удсан асуудал үүссэн хэдий ч тухай бүрд ойлголцож хамтран ажилласан. Дахин ийм зөрчил гаргахгүй байх тал дээр хариуцсан хүмүүст нь сануулав. Сар бүр ажлын байрны үзлэг хийдэг тул талбайн эмх цэгц хог хаягдал ил задгай хаях энэ тэр дээр асуудал бага байгаа юм. Сар бүрийн ажлын байрны хяналт үзлэгийн хуудсыг тайланд хавсаргав.



Зураг 34. “Спейшил Майнинг Сервисес” ХХК тэсэлгээний агуулахын харагдах байдал




Хүснэгт 19. Тээлгээний бодисын хэрэглээний бүртгэл

 "Спейшл Майнинг сервис" ХХК-ийн тээлгээний бодисуудын сар тутмын хэрэглээний бүртгэл						
Бодисын төрөл	Задтай эмульсийн тэрэх бодис	Аммиакийн шүү	Савлагатай эмульсийн тэрэх бодис	Хэрэглээний бүртгэл хийсэн огноо	Хэрэглээний бүртгэл мэдээлэл өгсөн: "Спейшл Майнинг сервис" ХХК-ийн тээлгээний инженер	Хянасан: "Терра Энержи" ХХК-ийн байгаль орчны ажилтан
Зориулалт	Хэмжих нэгж /кг/	Хэмжих нэгж /кг/	Хэмжих нэгж /кг/			
2024 он	Хэрэглэсэн	Хэрэглэсэн	Хэрэглэсэн			
1 сар	1024409	345401	4560	2024.02.03		
2 сар	850'003	255,009	456	2024.03.02		
3 сар	811'730.0	314'867.0	3'360.0	2024.04.06		
4 сар	534'351	306'608	9'142	2024.05.06		
5 сар	503'889.0	376'334.0	—	2024.06.06		
6 сар	394'868.0	179'104.0	—	2024.07.06		
7 сар	424'288.0	181'513	—	2024.08.14		
8 сар	553'570.0	245,044	—	2024.09.01		
9 сар	638'019	319,856	—	2024.09.30		
10 сар						
11 сар						
12 сар						
Жилийн нийт хэрэглээ						




Хүснэгт 20. Тээлгээний бодис хүлээн авсан бүртгэл

 "Спейшл Майнинг сервис" ХХК-ийн тээлгээний бодис хүлээн авсан сар тутмын мэдээ						
Бодисын төрөл	Задгай эмульсийн тээрэх бодис	Аммиакийн шүү	Савлагаатай Эмульсийн тээрэх бодис	Хяналт хийсэн огноо	Мэдээлэл өгсөн: "Спейшл Майнинг сервис" ХХК-ийн тээлгээний инженер	Хянасан: "Терра Энержи" ХХК-ийн байгаль орчны ажилтан
Зориулалт	Хэмжих нэгж /кг/	Хэмжих нэгж /кг/	Хэмжих нэгж /кг/			
	Хүлээн авсан	Хүлээн авсан	Хүлээн авсан			
2024 он						
1 сар	435000	255830	-	2024.02.03		
2 сар	440100	145100	13008	2024.03.02		
3 сар	625000.0	325550.0	-	2024.04.06		
4 сар	490000.0	267450.0	-	2024.05.06		
5 сар	520000.0	411400.0	-	2024.06.06		
6 сар	585000.0	143900.0	-	2024.08.01		
7 сар	315000	195500	-	2024.08.01		
8 сар	595000.0	248850.0	-	2024.09.01		
9 сар	595000	316200	9984	2024.09.01		
10 сар						
11 сар						
12 сар						
Жилийн нийт хэрэглээ						

9.2 Аюул осол болон гамшгаас хамгаалах төлөвлөгөө

Уурхайн үйл ажиллагааны хүрээнд Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг Онцгой Байдлын Ерөнхий Газрын харьяа Налайхын Уул уурхайн аврах ангиар батлуулсан. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Өмнөговь аймгийн ОБГ-аар батлуулж ажиллалаа.



Зураг 35. 2024 оны Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний батлагдсан нүүрнүүд

10.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн үйл ажиллагааны дүнд үүсэж буй хог хаягдлын байгаль орчинд ээлтэй, ангилах, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах зорилготойгоор ажиллаж байна.

Хүснэгт 21. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн хураангуй

№	Ангилал	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлт
1	Ахуйн	Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа энгийн хог хаягдлын гэрээг холбогдох байгууллагатай хийх Гэрээний дагуу зохицуулах	Төслийн талбай	Тонн	Жилийн турш	Ахуйгаас гарч буй хог хаягдлын “Говийн ноён өгөөж” ХХК-тай 2019 оноос хойш гэрээ байгуулан хог хаягдлыг гэрээний дагуу зохицуулж байна. 10.1 дэд бүлэгт дэлгэрүүлэн оруулав.
2	Ахуйн	Ноён сумын хуучин хог хаягдлын цэгийг засварлах	Ноён сумын хог хаягдлыг цэг	М ³	Тухайн жилдээ	Ноён сумын хог хаягдлын цэгт уурхай, Хур-Эрдэнэ баялаг ХХК болон Ноён сумын иргэд хог хаягдлаа хаядаг билээ. Тус хог хаягдлын хуучин цэг хогоор дүүрч шинэ хогийн цэгийн хог хаягдал талбайн ихэнх хэсэгт тархсан байсан юм. Компанийн зүгээс хуучин хог хаягдлын цэгийг ландфилл хийж, шинэ хогийн цэгийг 2 удаа түрэх ажлыг хийж гүйцэтгэлээ. 10.2 дэд бүлэгт дэлгэрүүлэн оруулав.
3	Аюултай	Ашигласан тос, тосолгооны материалыг дахин боловсруулах зорилгоор холбогдох компанид хүлээлгэн өгч, баримтыг бүрдүүлэх	Хаягдал тос цуглуулах цэг	Тонн	Жилийн турш	Ашигласан техникийн тос буюу аюултай хаягдлыг “Алтан Оршихуй” ХХК-д нийлүүлэх тухай гэрээг компани хооронд байгуулан хаягдлыг шилжүүлэн ашиглаж байна. 2024 оны хувьд компани 20-30 тонноор гэрээний дагуу 3 удаа хүлээлгэн өгөөд байна. “Алтан Оршихуй” ХХК-тай хийсэн гэрээний хугацаа дуусахаар “Ханбогд вейст менежмент центр” ХХК-



“Энхтунх Орчлон” ХХК-ийн 2024 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

						тай хамтарч ажиллахаар гэрээний түвшинд ярилцаад явж байна. Дэлгэрэхгүй мэдээллийг 10.2 дэд бүлэгт.
4	Ахуйн үйлдвэр	Хог хаягдалын бүртгэл хөтлөх	Төслийн талбай	Тонн	Жилийн турш	Хог хаягдлыг бүртгэлийг сар бүр хөтлөн явуулдаг ба гэрээний дагуу “Говийн ноён өгөөж” ХХК хүлээлгэн өгч байна. Хог хаягдлын бүртгэлийн хагас жилийн тайланд оруулан орон нутагт хүргүүлсэн бөгөөд хог хаягдлын төлбөрийг мөн орон нутгийн төсөвт жилээр нь төлсөн юм. 10.4 дэд бүлэгт дэлгэрүүлэн оруулав.
5	Ахуйн	Гэрээт байгууллагуудын хог хаягдал, хяналт тавьж, ажлын байрны үзлэг хийх	Төслийн талбай	Тонн	Жилийн турш	2023 оны хувьд уурхайн үйл ажиллагааны явцад 14 хоногт нэг удаа бүх гэрээт компанийн ажлын байрны үзлэгийг тогтмол хийж ажилласан. Ажлын байрны үзлэгээр илэрсэн зөрчлийг тухай бүрд хариу арга хэмжээ авч ажилласан. 10.5 хэсэгт дэлгэрүүлэн оруулав.

10.1 Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа энгийн хог хаягдлын гэрээг холбогдох байгууллагатай хийх гэрээний дагуу зохицуулах

Уурхайн талбайд үүсч буй хаягдлыг аль болох бууруулах, багасгах чиглэл барин ажиллаж байгаа бөгөөд үндсэн суурь нь хог хаягдлын ангилан ялгалт хийх, аль болох уурхайн талбай дээр хог хаягдлыг ихээр хуримтлуулахгүй байх бөгөөд компанийн хувьд Монгол улсын хууль журамд нийцсэн дотоод журмын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2024 онд дахин ашиглалтыг дэмжих зорилгоор иргэдийн хүсэлтийн дагуу поошиг, дугуй, 1 тонны цэвэр усны болон тосны сав, хаягдал мод зэргийг орон нутгийн иргэдийн хүсэлтийн дагуу хүлээлгэн өгсөн. Эмнэлгийн хог хаягдлыг Ноён сумын эмнэлэгтэй хийсэн хамтран ажиллах гэрээний дагуу хүлээлгэн өгч устгуулж байна. Ахуйгаас гарч буй дахин ашиглах боломжгүй хог хаягдлын “Товийн ноён өгөөж” ХХК-тай гэрээ байгуулан 7 хоногт 3-4 удаа хог хаягдал ачдаг машинаар уурхайд ирж авах замаар зохицуулж байна. Уурхайн орчимд тархсан ахуйн хог хаягдлыг 14 хоногт нэг удаа бүх нийтийн цэвэрлэгээ хийж ажиллаж байна.



Зураг 36. Хаягдал мод дугуйг иргэдийн хүсэлтийн дагуу хүлээлгэн өгөв.



Зураг 37. 1 тонны усны савыг мод услах зориулалтаар хүлээлгэн өгөв, Гэрээний дагуу Говийн ноён өгөөж ХХК ахуйн хог хаягдлыг хүлээлгэн өгч буй нь



Зураг 38. Уурхайн бүсэд орчны цэвэрлэгээ хийж буй байдал



БАТЛАВ:
“Говийн Ноён Өгөөж” ХХК-ийн
Захирал: Ц.Баатар-Эрдэнэ/



БАТЛАВ:
“Цагаан Өвөлжөө” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал: Матъяо Кауфорд/

ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭН УСТГАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2021 оны 11 дугаар сарын 28 өдөр

№ TE-CNT-0708 Өмнөговь аймаг Ноён сум

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Хог хаягдлын тухай хуулийн 10-р зүйлийн 10.2.3 - 10.2.5 дугаар зүйлүүдийг тус тус үндэслэн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж болон хог хаягдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгжийн хооронд зөвхөн энгийн хог хаягдлыг ачих, тээвэрлэх, зориулалтын цэгт хүргэх үйлчилгээг үзүүлэх зорилгоор байгуулав.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ТАЛУУД

Энэхүү Гэрээг нэг талаас Монгол улс, Өмнөговь аймаг, 1-р баг, Сайран, Залаа хороололд бүртгэлтэй “Говийн Ноён Өгөөж” ХХК (цаашид “Гэрээлэгч” гэнэ), нөгөө талаас Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Нарны зам - 91, Санроуд Барилга, 6-р давхарт байрлах “Цагаан Өвөлжөө” ХХК болон “Энхтунх Орчлон” ХХК (цаашид Үйлчлүүлэгч гэнэ) нарын хооронд байгуулав.


ГУРАВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

1. Үйлчилгээ үзүүлэх тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж уурхайн талбай руу нэвтрэх зөвшөөрлийг олгоно.
2. Жолоочийг сонгууруулах зүйл болон халдварт КОВИД-19 дархлаажуулалтын бүрэн тунг хийлгэсэн эсэхийг шалгасны үндсэн дээр уурхайн бүсэд нэвтрүүлнэ. Шаардлагатай бол КОВИД-19 шинжилгээний хариу нэхэх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд 3 хоногийн өмнө мэдэгдэнэ.

Зураг 39. Дахин ашиглах боломжгүй хог хаягдал цуглуулах, тээвэрлэх усгах үйлчилгээ үзүүлэх гэрээ

10.2 Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа энгийн хог хаягдлыг хаядаг Ноён сумын хог хаягдлын цэгийг засварлах

Ноён сумын хог хаягдлын цэгт уурхай, Хур-Эрдэнэ баялаг ХХК болон Ноён сумын иргэд хог хаягдлаа хаядаг билээ. Тус хог хаягдлын хуучин цэг хогоор дүүрч шинэ хогийн цэгийн хог хаягдал талбайн ихэнх хэсэгт тархсан байсан юм. Компанийн зүгээс хуучин хог хаягдлын цэгийг ландфилл хийж, шинэ хогийн цэгийг 2 удаа түрэх ажлыг хийж гүйцэтгэлээ.



Зураг 40. Хогийн цэгийн харагдах байдал




Зураг 41. Ноён сумын хог хаягдлын цэгийн сэргээн засварлаж, хуучин хогийн цэгт ландфилл хийсний дараа

10.3 Ашигласан тос, тосолгооны материалыг дахин боловсруулах зорилгоор холбогдох компанид хүлээлгэн өгөх

“Алтан оршихуй” ХХК-ийн “Ахуй Мандал” дахивар боловсруулах үйлдвэртэй уурхайн талбайгаас гарах хаягдал тосыг нийлүүлэх гэрээг 2023 онд 2 жилийн хугацаатай байгуулсан. Тус үйлдвэр Улаанбаатар хотын Багахангай дүүрэгт байрлах бөгөөд 2011 онд ашиглалтад орсон юм. 10-12 тонн хаягдал тос дахин боловсруулж Евро-4 стандартыг хангасан 7-8 тонн дизель түлш үйлдвэрлэх хүчин чадалтай. Тус компанид 2024 онд хаягдал тосыг 20 - 30 тн-оор гээд 3 удаа хүлээлгэн өгсөн билээ. Мөн компани бохир тос соруулах тусгай зориулалтын машинтай болсон юм. Хаягдал тос хүлээлгэн өгсөн баримтыг тайланд хавсаргав.



Зураг 42. Алтан Оршихуй ХХК-д хаягдал тос хүлээлгэн өгч буй байдал



Зураг 44. Алтан Оршихуй ХХК-тай хийсэн гэрээ



Зураг 43. Бохир тос соруулах зориулалт бүхий машин

10.4 Хог хаягдалын бүртгэл хөтлөх

Хог хаягдлын бүртгэлийг дэд бүтцийн хэлтсийн хог хаягдал хариуцсан туслах ажилчид сар бүр бүртгэж байгаль орчны мэргэжилтэнд бүртгэлийн хуудсыг хураалгадаг. Хог хаягдлын сар бүрийн бүртгэлийг Ноён сумын байгаль хамгаалагчид тайлагнадаг юм. Нийт хог хаягдлын график үзүүлэлтийг харахад хог хаягдлын ихэнх нь шатаах буюу дахин ашиглах боломжгүй хог хаягдал эзэлж байгаа юм.

Хүснэгт 22. Хог хаягдлын бүртгэлийн нэгтгэл

Сар	Хуванцар /м3/	Хоолны хягдал /м3/	Шил /м3/	Шатаах /м3/	Нийт хог хаягдал /м3/
1-р сар	0.2	4	0.10	20	24
2-р сар	0.2	3	0.10	27	30
3-р сар	0.2	5	0.10	28	33
4-р сар	0.2	3	0.20	24	27
5-р сар	0.2	2	0.10	21	23
6-р сар	0.2	2	0.20	32	34
7-р сар	0.2	4	0.10	45	49
8-р сар	0.2	2	0.10	35	37
9-р сар	0.2	6	0.10	32	38
10-р сар	0.0	0.0	0.0	0.0	0
11-р сар	0.0	0	0.00	0	0
12-р сар	0.0	0	0.00	0	0
Нийт	1.8	31	1.1	264	298




График 10. Хог хаягдлын эзлэх хувийг харуулсан байдал




График 11. Хог хаягдлыг саруудаар эзлэх хувийг харуулав

10.5 Гэрээт байгууллагуудын хог хаягдал, хяналт тавьж, ажлын байрны үзлэг хийх

2024 оны 3-р улирлын байдлаар бүх гэрээт байгууллагад байгаль орчны ажлын байрны үзлэгийг сард нэг удаа гэсэн дотоод төлөвлөгөөтэй ажилласан. Ажлын байрны үзлэгээр илэрсэн зөрчлийг тухай бүрд хариу арга хэмжээ авч ажилласан. Уурхайн кемпийн хог хаягдал, цэвэрлэгээ үйлчилгээг Монруд ХХК хариуцан ажилладаг. Мөн дараах хүснэгтээр 2024 оны 09 дүгээр сард Засварын хэсэг дээр Байгаль орчны ажлын байрны үзлэг хийсэн хуудас, болон хариу арга хэмжээ авсан байдлыг жишээ байдлаар оруулав. Ийм байдлаар Байгаль орчны ажлын байрны үзлэг хийснээр ажлын байрны эмх цэгц багасч зөрчил бага илрэх болсон юм. Энэ гэрээт компани бага байгаатай шууд холбоотой. Үзлэгийн хуудсыг жишээ байдлаар тайланд хавсаргав.



11.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагааны явцад Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Ашигт малтмалын тухай болон бусад хуулиудын дагуу хяналт шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлалыг хангасан багаж тоног төхөөрөмжөөр хяналт шинжилгээг гүйцэтгэж байна. Хяналт шинжилгээний ажлын хүрээнд усны шинжилгээг улирал бүр, хөрсний шинжилгээг улирал бүр, агаарын хяналт шинжилгээг жилд нэг удаа эрх бүхий итгэмжлэгдсэн лаборатори, шинжээчээр хийлгэн ажилласан. Мониторингийн ажлын хүрээнд сар бүр нөлөөллийн 8 гар худаг, уурхайн хяналтын 3 цэгт усны түвшний хэмжилт, гадаргын усны 3 цэгт фотомониторинг , тоосны нарийн болон бүдүүн ширхэгтэй тоосонцрийн хэмжилтийн уурхайн нөлөөллийн 6 цэг, нүүрс тээврийн зам дагуу 4 цэгт, агаарын хэм, дуу чимээг нөлөөллийн цэгүүдэд сар бүр, тэсэлгээний дуу чимээг жилд нэг удаа, амьтны болон ургамлын судалгааг мөн нөлөөллийн бүсэд хийж ажиллав.

Хүснэгт 23. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хураангуй

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Шинжилгээ явуулах төрөл, арга хэлбэр	Байршил	Давтамж	Биелэлт
1	Цаг уур /уур амьсгалын хэмжилт/	Агаарын хэм, салхины хурд, чиглэл,	Уурхайн талбайд	Сар бүр /зөөврийн багаж/	Салхины хурд агаарын хэм, салхины чиглэлийн нөлөөллийн бүсийн 6 цэгт сар бүр зөөврийн багажаар хэмжилт хийж ажиллаж байна. Дэлгэрэнгүйг 11.1 дэд бүлэгт оруулав.
2	Агаарын чанар тоос	PM2.5 ба PM10	Уурхайн талбай орчимд байрлах тоосны хяналтын 6 цэгт, зам дагуу 4 цэгт	Сар бүр	Нөлөөллийн бүсийн 6 цэгт сар бүр бүдүүн болон нарийн ширхэгтэй тоосонцрыг Dusttrak II багажаар хэмжилт хийсэн. Дэлгэрэнгүйг 11.2 дэд бүлэгт оруулав.
3		Тоосны хэмжилт хөндлөнгийн байгуулгаар хийлгэх	Уурхайн доторх 4 цэгт	Жилд нэг	Уурхайн хүрээнд 4 байршилд агаарын чанарын хэмжилтийг жилд нэг удаа 1 удаа хийлгэхээр төлөвлөгөөнд тусгасан. Гэвч зайлшгүй хийх шаардлагатай 3 цэг нэмэгдэж нийт 7 цэгт Ногоон титэм ХХК-аар агаарын шинжилгээг хийлгэв. Дэлгэрэнгүйг 11.3 дэд бүлгээс



“Энхтунх Орчлон” ХХК-ийн 2024 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

4	Дуу шуугиан	Орчны дуу чимээ /dB/	Нөлөөллийн бүсийн 6 цэгт	Улирал тутам	Уурхайн нөлөөллийн бүсийн 6 цэгт улирал бүр дуу шуугианы хэмжилтийг хийхээр төлөвлөсөн хэдий ч тоосны хэмжилтийн үед хамтатган хийснээр сар бүрээр үзүүлэлтийг гаргав. 11.4 дэд бүлэгт дэлгэрэнгүй байдлаар орууллаа.
			Тэсэлгээний явцад тэсэлгээ хийж буй газраас 500м зайнаас.	Жилд 1 удаа	Тэсэлгээний явцад жилд нэг удаа дуу шуугиан хэмжихээр төлөвлөсөн юм. Энэ оны хувьд тэсэлгээнээс 500м зайнаас 2 удаа хэмжилтийг хийж ажиллаа. 11.4 дэд бүлэгт дэлгэрүүлсэн байдлаар оруулав.
5	Усны чанар, хяналт	Усны түвшин, гүн	Хяналтын 3 цооног, Малчдын 8 гар худагууд, Задгай усны 3 цэг, Кемпийн гүний худаг	Сар бүр	Уурхайн бүсэд мониторингийн 3, уурхайн нөлөөллийн бүсийн малчны гар худаг 8, нийт 11 цэгт сар тутам хэмжилтийг хийж ажилласан мөн Фотомониторинг 3 цэгт сар бүр хийгдсэн юм. Дэлгэрэнгүйг 11.5 дэд бүлэгт оруулав.
6		Химийн дэлгэрэнгүй		Улиралд нэг удаа	Улирал бүрийн усны дээжийг Өмнөговь аймгийн МХГ-т, Геологийн төв лаборатори, Усны газрын лабораторид дээжийг хүргүүлэн шинжлүүлсэн. Дэлгэрэнгүйг 11.6 дэд бүлэгт оруулав.
		Хүнд металл	Шүүрлийн ус		
7	Хөрсний чанар	Хөрсний чанар, хүнд металл	Уурхайн хөрсний хяналтын цэгүүдэд	Улиралд нэг удаа	Уурхайн хүрээнд 9 байршилд хөрсний чанар, хүнд металлын шинжилгээг улиралд 1 удаа хийгддэг ба Өмнөговь аймгийн МХГ, Улаанбаатар хотод Хөрс судлалын лабораторид хүргэж шинжилж байна. Дэлгэрэнгүйг 11.7 дэд бүлэгт оруулав.
8	Амьтны судалгаа	Талбайн хэмжээнд тодорхой маршрутаар	Лицензийн талбай	Жилд нэг удаа	Амьтны судалгааг өнгөрсөн оны судалгаа хийсэн маршрутын ойролцоо талбайн хүрээнд нэг өдрийн турш хийж гүйцэтгэв. Дэлгэрэнгүйг 11.8 дэд бүлэгт.
9	Ургамал бичиглэл	Талбайн хэмжээнд тодорхой цэгүүдэд	Лицензийн талбай	Жилд нэг удаа	Уурхайн ашиглалтын талбайн ойролцоо 4 цэгт ургамлын бичиглэл /геобатоник/ судалгааг хийж ажиллалаа. Дэлгэрэнгүйг 11.9 дэд бүлэгт оруулав.

11.1 Цаг уур /уур амьсгалын хэмжилт/

Нөлөөллийн бүсийн цаг уурын амьсгалын хэмжилтийг график хэлбэрээр харууллаа. Зөөврийн багажаар агаарын хэм, салхины чиглэл, хурд, харьцангуй чийгшлийн хэмжилтүүдийг зөөврийн багажаар сар бүр хийж ажиллаа. Дараах графикуудад 2024 оны 1 сараас 2024 оны 10 сар хүртэлх тайлант хугацаанд хамаарагдах хэмжилтүүдийг үзүүлэв.




График 12. Нөлөөллийн бүсийн сар бүрийн харьцангуй чийгшил, салхины хурдыг харуулав.




График 13. Агаарын хэмийн сар бүрийн хэмжилтийн үр дүнг харуулав.

Дээрх графикуудаас харахад агаарын хэм өдөртөө -18 - +33 градус хүртэл улирлаасаа шалтгаалж хэлбэлзэж байгаа юм. Салхины хурд хамгийн идэвхтэй сар 4 сард 14-15 мөрт/сек, хамгийн салхины идэвхжилт бага сарууд нь өвлийн адаг, зуны эхэн эхэн, дунд, адаг сарууд тодорхойлогдож байгаа юм. Харьцангуй чийгшлийг харахад 7, 8, 9, 10 саруудын үзүүлэлт өссөн нь тухайн жилийн дулааны улиралд хур бороо элбэг газар чийгтэй байсантай холбоотой гэж харж байна.




Зураг 45. Дуу чимээний хэмжилт хийж буй байдал



Зураг 46. Уур амьсгалын хэмжилтийн зөврийн багажнууд, Нөлөөллийн бүс дээр хэмжилт хийж буй байдал

11.2 Агаарын чанар тоос /хэмжилт үр дүнгийн мэдээлэл/

Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөс үүдэлтэй орчны тоосжилтыг хянах зорилгоор сонгосон хяналтын цэгүүдэд, тодорхой аргачлалын дагуу тоосны мониторингийн ажил хийгддэг бөгөөд хэмжилтийн үр дүнг MNS 4585:2016 Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага стандартад заагдсан хүлцэх агууламжтай харьцуулан дүгнэдэг. Тоосны хэмжилтийг Dust Trak II маркийн багажийг ашиглан 30 минутын хугацаа давтамжтайгаар хэмжиж байна. Тоосны концентратын хэмжилтэд PM10, PM2.5 тоосонцрыг гол үзүүлэлт тодорхойлсон.



Зураг 47. Уурхайн тоосны хэмжилтийн нөлөөллийн бүсийн 6 цэгийн байршилыг харуулав.






График 14. Уурхайн нөлөөллийн бүсийн нарийн болон бүдүүн ширхэгтэй тоосны хэмжилтийн үр дүнг харуулав

Уурхайн нөлөөллийн бүсэд хийгдэж байгаа 2.5 болон 10 мкг/м³ агуулагдаж байгаа тоосны хэмжилтийн үр дүнг графикаас харахад жилийнхээ эхэн, жилийн адаг буюу хаврын эхэн сарууд намрын эхэн сарууд байгаа юм. Энэ үед салхины эрчим бага зэрэг нэмэгдэж хуурайшилт идэвхтэй байдаг үеүд. Тиймээс энэ үед уурхайн хувьд усалгаа дээр анхаарч ажиллах нь зүйтэй. Нөлөөллийн бүсийн тоосны хэмжилтийг сар бүрийн 20-нд хийдэг ба тухайн өдрийн салхины эрчмээс хэмжилтийн үр дүн шалтгаалах нэг нөхцөл гэж харж байна.



Зураг 48. Нөлөөллийн бүсийн 6 цэгт тоосны хэмжилт хийж буй байдал

Дараах зурагт харуулснаар нүүрс тээврийн зам дагуу хийгдэж байгаа 2.5 болон 10 мкг/м³ хэмжилтийн цэгүүдийг харуулав. Агуулагдаж байгаа тоосны хэмжилтийн үр дүнг мөн графикаар оруулсан юм. Графикаас харахад тоосны хэмжилтийн үзүүлэлт Стандарт хэмжээнд байгаа нь өмнөх оноос илүү хур тунадас элбэгтэй жил байсныг илтгэж байна. Оны эхний 10 сарын байдлаар нүүрс тээврийн замын тоосны хэмжилтийн үр дүнгээс харахад хаврын саруудад бусад сартай харьцуулахад үзүүлэлт бага зэрэг өндөр гарсан нь тухайн сарын салхины эрчим идэвхтэй байдаг тул замыг усалгааг аль болох нэмэгдүүлэх сайжруулах хэрэгтэй юм. Байгаль орчны ажилтнуудын зүгээс тогтмол усалгааг сайжруулах тал дээр шахаж ажиллаж байна.



Зураг 49. Нүүрс тээврийн замын тоосны хэмжилтийн цэгүүдийн харуулсан план болон нүүрс тээврийн замд тоосны хэмжилт хийж буй байдал





График 15. Нүүрс тээврийн замын нарийн болон бүдүүн ширхэгтэй тоосонцорын хэмжилтын үзүүлэлт

11.3 Тоосны хэмжилт хөндлөнгийн байгуулгаар хийлгэх


Хөндлөнгийн байгуулгаар тоосны хяналт шинжилгээг “Грийн Кроун” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн. Уурхайн бүсэд уурхайн засварын газар, ШТС, уурхайн бүс, Кемп зэрэг газруудад нарийн ширхэгтэй тоосонцор мөн агаар дахь азотын давхар исэл, хүхэрлэг хий, озон, нүүрс төрөгчийн дутуу исэл мөн тоосны нарийн болон бүдүүн ширхэгтэй тоосонцор зэрэг нэгдлүүдийг 4 цэгээс авч шинжилгээ хийлгэхээр төлөвлөсөн хэдий ч нэмэлтээр нүүрс тээврийн зам, уурын зуух, уурхайн оффис зэрэг 3 цэг нэмэгдэж нийт 7 цэгт дээрх үзүүлэлтүүдээр хийлгэсэн юм. /Ногоон титэм ХХК-ийн шинжилгээний дүнг тайланд хавсаргав/



Зураг 50. Ногоон титэм ХХК-ийн мэргэжилтэнүүд хэмжилтын цэгүүдэд хэмжилт хийж буй байдал

11.4 Дуу шуугиан /Орчны дуу чимээ dB/

Уурхайн нөлөөллийн бүсийн 6 цэгт улирал бүр дуу шуугианы хэмжилтийг хийхээр төлөвлөсөн гэвч дараах графикт сар бүрээр хэмжилт хийсэн үр дүнг үзүүлээ. Хэмжилтийн сар бүрийн тогтсон өдөр хийдэг ба уурхайн нөлөөллийн бүсийн 6 цэг дээр тоосны хэмжилт хийх үед хамтагтан хийсэн юм. Дуу шуугиан ихэссээр мэдээж нөлөөллийн бүсийн оршин суугчид, зэрлэг ан амьтанд сөргөөр нөлөөлөх үр дагавар гарах учир стандарт хэмжээнээс давсан эсэхийг графикийн үр дүнгээс харж болно.



Зураг 51. Нөлөөллийн бүсийн дуу шуугианы хэмжилтийн график үзүүлэлт болон дуу чимээг зөврийн багажаар хэмжиж буй байдал


Тэсэлгээний явцад 500 метр зайнаас дуу чимээг хэмжилтийг 2 удаа хийж ажиллаа. Тэсэлгээний явцад 500 метр радиус дотор хүн, мал амьтан байхыг хориглодог тул зөвшөөрөгдөх зайнаас хэмжилтийг хийсэн юм. Хэмжилтийн үр дүнг дараах зурагт үзүүлэв.




*Зураг 52. Тэсэлгээний явцад 500 метр зайнаас дуу чимээг зөөврийн
багажаар гүйцэтгэж буй байдал*

10.5 Усны чанар, хяналт, мониторинг

Уурхайн нөлөөллийн бүсийн малчны 8 худаг, уурхайн хяналтын 3 цэгт, уурхайн унд ахуйн худаг зэрэгт сар бүр хэмжилтийг хийж ажиллалаа. Хэмжилтийн үр дүнг дараах графикуудад харуулав.



Зураг 53. Уурхайн нөлөөллийн бүсийн малчны худгийн усны түвшний хэмжилтийн график үзүүлэлт болон хэмжилт хийж буй байдал




Зураг 54. Уурхайн усны хяналтын цэгийн усны түвшний үр дүнгийн график болон усны түвшний хэмжилт хийж буй байдал мөн Ноён сумын байгаль хамгаалагч хяналтын цооногийн түвшний хэмжилтийг давхар шалгаж буй нь



Зураг 55. 1, 2, 3-р улирлын фотомониторингийн харьцуулсан зураг

11.6 Усны чанарын шинжилгээ

2024 онд төслийн мониторингийн 12 цэгүүдээс улирал бүр усны дээжийг авч итгэмжлэгдсэн лабораторид химийн, хүнд металлын, ундны усан дээр бактериологийн шинжилгээг хийлгэж үр дүнг хянаж ажилласан. */Шинжилгээний дүнг хавсралтаас харна уу/* Шинжилгээний дүнгээс харахад Одоогоор стандартаас хэтэрсэн үзүүлэлт гараагүй байгаа. /MNS ISO 0900;2018/ Усны чанар рН тодорхойлох стандартад заагдсан унд ахуйд хэрэглэх усны рН 7 байдаг бол уурхайн шүүрлийн болон унд ахуй, малчны худгуудын шинжилгээний үзүүлэлт 7.5 дээш ЭКВ буюу бага зэрэг хатуулаг ус юм. Унд ахуйд усыг цэвэршүүлж ашиглаж байна.



Зураг 56. Унд ахуйн усны шинжилгээний дээж авдаг цэгүүдийн байршилг зурагт харуулав



Зураг 57. Уснаас дээж авч шинжилгээнд хамруулахаар бэлтгэж буй байдал

10.7 Хөрсний чанарын шинжилгээ

2021 онд уурхайн хөрсний хяналт шинжилгээний цэгүүдийг шинэчлэн тогтоосны дагуу 2022, 2023, 2024 онуудад хяналтын 9 цэгээс дээжлэлтийг улирал тутам хийж ажилласан. Хөрсний чанарын шинжилгээг Өмнөговь аймгийн МХГ лаборатори, Улаанбаатар хот дахь хөрсний шинжилгээ хийдэг итгэмжлэгдсэн лабораториудад хийлгэж чанарыг хянаж ажилласан. Хөрсний чанарыг хянахдаа гол төлөв химийн шинж чанар, физик шинж чанар болон хүнд металл, бохирдлын агууламжуудыг тус тус тодорхойлуулж хөрсний бохирдол үүсэж байгаа эсэхийг хянаж ажилласан юм. Шинжилгээний дүнгүүдийг харахад хүнд металл стандарт хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт байхгүй юм. Харин шимт хөрсний дээжийн шимэрхэг байдал маш ядуу буюу үржил шим бага байна. /Дэлгэрэнгүй шинжилгээ ний дүнг тайланд хавсаргав/



Зураг 58. Хөрсний дээжийг шинжилгээнд хамруулахаар бэлтгэж буй байдал

10.8 Амьтны судалгаа

Зорилго: Уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас уурхай орчмын том хөхтөн, нүүдлийн болон суурин шувуудын тархац, байршил нутагт нөлөөлөх байдлыг судлах, том хөхтөн амьтны, тоо толгой, шувуудын тархалтыг тухайн жил бүр гаргах.

Ажиглалтын талбай, арга зүй: Ажиглалтыг 2024 оны 08 дугаар сарын 10-ний өдөр уурхайн ашиглалтын лицензийн талбай болон нөлөөллийн бүсэд тааралдсан амьтны байршил, тоо толгойг тэмдэглэсэн. Уг судалгаагаар нийт 6 зүйлийн шувуу, 3 зүйлийн хөхтөн нийт 91 зүйлийн амьтан харж тэмдэглэсэн.



Зураг 59. Амьтны судалгаа мониторинг хийсэн замын маршрут харуулсан байдал

Хүснэгт 24. Амьтны ажиглалтын нэгдсэн мэдээлэл

№	Монгол нэр	Их усны хяр	Ар задгай	Ямааг	Хөтөл амгалан зүүн талаар	Ихэрийн араар	Хур Эрдэнэ ХХК-ийн зүүн урд	Урлын голын эхэн хэсэгт	Хатуугийн талд	Өвөр булгийн ойролцоо	Уурхайн хотхоны зүүн талруу	Нарангийн булаг	Уртын голын адагруу	Пит-7 баруун хойд уулан дунд	Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайд	Нийт тэмдэглэгдсэн бодгалийн тоо
1	Аргаль	1								1						2
2	Эрээн хахилаг	2		3			2						2			9
3	Цөлийн чогчиго	1	2		1		1		1			1		1	1	9
4	Хар хэрээ															0
5	Тагтаа	3		4		2		1		1		4		4		19
6	Бор туулай	1		1				1			2		1		1	8
7	Хар сүүлт	2			6				2					3	1	14
8	Янгир ямаа					3										2
9	Өрөв тас	1			1				1		1		2			6
10	Шоорон эвэрт болжмор	4		2	2		4	5	1	1		1		2		22
Тухайн газар ажиглагдсан амьтдын тоо		15	2	10	10	5	7	7	5	3	3	6	5	10	3	91

Ажиглалтыг Уртын голын эхэн, Уртын голын адаг руу, Пит-7-ийн баруун хойд уулаар, Нарангийн булаг, Нарангийн булгийн хойд уул, Хатуугийн тал, Ар, Өвөр задгай, Ихрийн араар, Хөтөл амгалан зүүн, зүүн урдуур, Хур Эрдэнэ ХХК-ийн зүүн тал, Уурхайн хотхоны ойролцоо, Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн орчим гэсэн замналаар явж гүйцэтгэсэн. Тус замналаар явахад хөхтөн амьтнаас 3 янгир, 14 орчим хар сүүлт, 8 бор туулай тааралдсан бол шувуудаас 9 эрээн хахилаг, 6 тас, шоорон эвэрт болжмор 22, цөлийн чогчиго 9, аргаль угалз 2, тагтаа 19 бүртгэгдсэн. Бид өглөө ажиглалтаа 07 цагт эхлүүлсэн бөгөөд цаг агаарын байдал +25 орчим хүртэл халуун байсан бөгөөд үдээс хойш нарны элч буурч +20, +22 градус хүрч бага зэргийн сэвэлзүүр салхитай байлаа.



Амьтан харагдах байдлын мэдээлэл: Амьтны харагдах байдлын мэдээллээр уурхайн биологийн нөхөн сэргээлтийн талбайн 2 туулай, Биологийн нөхөн сэргээлтийн талбай ойролцоо 3 янгир ямаа, Уртын голын адагт таарсан 2 хар сүүлт зээр, хөв цөөрөм дээр 2 хэсэг ангирын сүрэг нь бусад хэмжилт судалгааны үед тааралдсан

ANIMALS MONITORING RECORD SHEET

DATE: 2024-08-10

№	Animal name/Амьтны нэр	Point /coordinate			Бодьгалын тоо/Species				Амьдрах орчин/ Home range	Байрлаж буй газрын нэр/ Name of location
		Easting	Northing	ДДА/ Height	Эр/ male	Эм/ female	Төл/ Sprout	Нийт тоо		
1	Аргал	46°52'09.94"	102°21'02.86"		1	-		1	Уртын болз	Уртын тал
2	Бор түүдэй	43°03'08.17"	102°16'02.45"		-	3		3	Хад гургуураг	Уртын тал
3	Бор түүдэй	43°02'41.00"	102°18'56.29"		1	-		1	Хөв, бут	Бургастий газар
4	Амьтан ямаа	43°42'26.23"	102°16'21.01"		2	-		2	Урн, хар	Уртын болз
5	Хар сүүлт	43°06'03.26"	102°15'06.40"		-	3		3	Хөв, бутны	Хөв тал
6	Майтаа	43°18'58.32"	102°18'21.11"		12	-		12	Урн эс газар, майтаа	
7	Уртын сүрэг	43°08'17.37"	102°25'09.02"		-	4		4	Хөв, бургаас	Бургаас
8	Хар сүүлт	-	-	-	-	-		0		
9	Уртын сүрэг	43°17'01.88"	102°13'06.52"		12	-		12	Урн эс газар, майтаа	Хөв тал
10	Бор түүдэй	43°06'48.27"	102°23'16.95"		-	2		2	Хөв, бут	Бургастий газар
11	Бор тас	43°04'03.66"	102°21'20.15"		2	-		2	Урн, хар болз, майтаа	
12	Аргал	43°01'33.28"	102°16'46.92"		-	1		1	Уртын болз	Уртын тал
13	Хар сүүлт	43°02'15.33"	102°23'42.17"		9	-		9	Хөв бургаас	Хөв тал

Measured by:	М. Вендрова Р. Валерьян	Signature:	
Reviewed by:		Signature:	

Зураг 60. Амьтны ажиглалтын бүртгэлийн хуудас



Зураг 61. Биологийн нөхөн сэргээлтийн ойролцоох янгир ямаа болон Хөтөл амгалан, Ар задгай, Хатуугийн хярд тааралдсан хар сүүлтүүд



Зураг 62. Хээрийн судалгааны үеэр таарсан шудууд

10.9 Ургамлын бүрхэцийн судалгааны мэдээлэл

Уурхай орчмын ургамлын бүлгэмдлийн төлөв байдлыг ажиглах зорилгоор уурхайн орчимд сонгосон 4 цэгт геоботаникийн бичиглэл хийсэн. 2022, 2023 онд ургамлын бичиглэл хийсэн талбайд энэ онд дахин геоботаникийн бичиглэл хийлээ.

Хүснэгт 25. Ургамлын /геоботаник/ бичиглэл хийсэн цэгийн байршил

№	Хяналтын цэгийн дугаар	Байршил	Солбицол	
			Уртраг	Өргөрөг
1	BNU-P-01	Ихэрийн ард	N=43 ⁰ 07' 36"	E=102 ⁰ 22' 45"
2	BNU-P-02	Уртын голын баруун	N=43 ⁰ 03' 08"	E=102 ⁰ 19' 18"
3	BNU-P-03	Кемпийн ард	N=43 ⁰ 05' 42"	E=102 ⁰ 19' 10"
4	BNU-P-04	Биологи нөхөн сэргээлтийн талбайн урд	N=43 ⁰ 05' 37"	E=102 ⁰ 19' 27"

Судалгааны үр дүн: Ургамалжилтын хэв шинж нь баглуур-таана-хялганат-харгана бүлгэмдэл бүхий цөлөрхөг хээрийн шинжийг агуулсан бөгөөд энд жижиг уул толгодын энгэр бэлээр *Anabsis brevifolia* /усан хамхуул/, *Reaumuria soongorica* /бударгана/, *Stipa glareosa* /Сайрын хялгана/, уул толгодын хоорондох сайр садрагаар *Zygophyllum xanthoxylon* /таана/, *Asterothamnus centra-asiaticus* /хөмүүл/, *Achinoderum splendens* /Гялгар дэрс/, *Nitraria sibirica* /харгана/, харин тэгш тал хөндийгөөр *Stipa glareosa* /Сайрын хазаар/, *Asterothamnus centra-asiaticus* /тэхийн шээг/, *Anabsis brevifolia* /Тагжгар баглуур/, *Reaumuria soongorica* /Улаан, бор бударгана/ зонхилон тархсан байна. Дээрх зонхилон тархсан ургамалууд нь маш ядуу, тарчиг зүйлийн тоо нь өмнөх онуудад буурсан үзүүлэлтэй байсан. Харин энэ онд хур бороо элбэгтэй байсанаар зүйлийн тоо нэмэгдэж ургамлын бүрхэвч нэмэгдэж, ургамлын өсөлт сайтай байгаа юм.

Хүснэгт 26. Ургамалын бичиглэл хийсэн цэгүүдийн ажиглалтын төлөв байдал

№	Бүлгэмдлийн зураг	Ургамалжилтын төлөв
1		<p>Ихэрын арлуу тоосны 05 дугаар хэмжилтийн цэгийн хажууд оролцоо. Уул толгодын арын харгана бут-таана хялгана бүлгэмдэлтэй.</p> <ul style="list-style-type: none"> ❖ Зонхилогч: Бут, хялгана, таана, хөмүүл, усан хамхуул ❖ Дэд зонхилогч: Таана, усан хамхуул ❖ Бүрхэц: 70-80% ❖ Дундаж өндөр: 10-50см ❖ 10м² дахь зүйлийн тоо: 5.
2		<p>Биологийн нөхөн сэргээлтийн талбайн урд хялгана-дэрс-баглуур бүлгэмдэлтэй.</p> <ul style="list-style-type: none"> ❖ Зонхилогч: Бут, Бударгана, дэрс, усан хамхуул ❖ Дэд зонхилогч: Бут, Дэрс ❖ Бүрхэц: 80% ❖ Дундаж өндөр: 10-50см ❖ 10м² дахь зүйлийн тоо: 5.
3		<p>Кемпийн арын хоолой хөндийн баглуур-таана-хялганат бүлгэмдэлтэй.</p> <ul style="list-style-type: none"> ❖ Зонхилогч: Баглуур, хялгана, харгана, тэхийн шээг, хотир, хөмүүл ❖ Дэд зонхилогч: Хялгана, таана ❖ Бүрхэц: 80-90% ❖ Дундаж өндөр: 10-30см ❖ 10м² дахь зүйлийн тоо: 6.
4		<p>Уртын голын баруун чулуурхаг сөөг оролцсон Голын зүлэг ширэг - хялганат бүлгэмдэлтэй.</p> <ul style="list-style-type: none"> ❖ Зонхилогч: Зүлэг, Баглуур, хялгана ❖ Дэд зонхилогч: Зүлэг ширэг ❖ Бүрхэц: 100% ❖ Дундаж өндөр: 5-10см ❖ 10м² дахь зүйлийн тоо: 3.



12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 27. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө биелэлтийн хураангуй

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцагч	Биелэлт
1	Байгаль орчины тэмдэглэлт өдрүүдэд Ноён сумын ЕБС-ын хүүхдүүдэд экологийн боловсрол олгох ажлыг зохион байгуулах	Тухайн жилдээ	Байгаль орчин, Орон нутаг	Ноён сумын ЕБС-ын сурагчдад экологийн боловсрол олгох үүднээс Дэлхийн усны өдрөөр “Ой ба Ус” уриатай өдөрлөгийг зохион байгуулсан. Мөн Өмнөговь аймагт зохион байгуулсан Өмнөговь аймгийн нийт сумдын сурагчдын дундах Дэвжээ тэмцээнд Ноён сумын сурагчдыг дэмжиж оролцсон зэрэг мэдээллийн дэлгэрэнгүй байдлаар 12.1 дэд бүлэгт оруулав.
2	Шинэ ажилтан, албан хаагчдыг байгаль орчин, аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах	Жилийн турш	Байгаль орчин ХАБЭА хэлтэс	Шинэ ажилтны сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 15-ны байдлаар 955 ажилтанд орсон байна. 2024 шинэ ажилтан болон 3 сараас дээш хугацаагаар уурхай дээр ирээгүй ажилтнуудад сургалтыг орсон юм. Дэлгэрэнгүй мэдээллийг 12.2 дэд бүлэгт.
3	Уурхайн хэмжээнд стандартын бус нүхэн жорлонг халж эко стандартын дагуу соруулдаг нүхэн жорлон болгох	Тодорхойгүй	Байгаль орчны хэсэг	2024 онд зориулалтын бус 3 нүхэн жорлон байсанг стандартад нийцсэн соруулдаг Эко модон жорлонгоор солив. Дэлгэрэнгүйг 12.3 дэд бүлэгт.
4	Усны мониторингийн цооногийг нэмэх хашаа , хаягжуулалт хийх	Тухайн жилдээ	Удирдлага Байгаль орчны хэсэг	Биологийн нөхөн сэргээлтийн талбай явах зам дагуу усны хайгуул хийгээд үлдсэн байсан цооногийн хашаалж хамгаалалтанд авч усны мониторингийн хяналтын цооног болгож хамгаалалтанд авав. Дэлгэрэнгүй мэдээллийг 12.4 дэд бүлэгт оруулав.
5	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих /Ноён суманд заг болон мод тарих/	Тухайн жилдээ	Удирдлага Байгаль орчны хэсэг	Тэрбум хөтөлбөрийн хүрээнд Ноён сумын Ганзагат багийн нутаг Цоохондойд 5 га, Ноён сумын төвд 5 га нийт 10 га газар Заг, хайлаас, сухай модыг тарих ажлыг хийв. 12.5 бүлэгт дэлгэрэнгүй оруулав.
6	Байгаль орчны аудитыг мэргэжлийн компианаар гүйцэтгүүлэх	Тухайн жилдээ	Удирдлага Байгаль орчны хэсэг	Байгаль орчны Аудитыг мэргэжлийн компани болох “Энвайрментал Комплайц” ХХК-аар гүйцэтгүүлэв. Дэлгэрэнгүй мэдээллийг 12.6 дэд бүлэгт оруулав.

12.1 Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдэд

Ноён сумын ЕБС-ын сурагчдад экологийн боловсрол олгох үүднээс Дэлхийн усны өдрөөр “Ой ба Ус” уриатай өдөрлөгийг зохион байгуулсан. Тус өдөрлөгийн үеэр усны талаар сургалтыг сурагчид болон албан хаагч нарт орж сурагчдын дунд хөгжөөнт болон танин мэдэхүйн тэмцээн уралдаан албан хаагчдын дунд АХА тэмцээн зэрэг нэг өдрийг усны талаарх мэдлэг мэдээлэл олгох ажлыг Байгаль хамгаалагчтай хамтарч зохион байгуулсан. Мөн Өмнөговь аймагт зохион байгуулсан Өмнөговь аймгийн нийт сумдын сурагчдын дундах ус ба энхтайван уриатай “Дэвжээ” тэмцээнд Ноён сумаас оролцсон багш, сурагчдыг дэмжиж тэмцээнд оролцох зардал /тэмцээний хувцас хэрэглэл, хоол унд, байрлах байр, машин тэрэг/ зэргийг компанийн зүгээс хариуцан оролцсон юм.



Зураг 63. Ноён сум болон Өмнөговь аймаг дээр зохион байгуулсан өдөрлөгүүдийн хэсгээс

12.2 Шинэ ажилтан, албан хаагчдыг байгаль орчин, аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах

Шинэ ажилтны сургалтыг 2024 оны 10 дүгээр сарын 15-ны байдлаар 955 ажилтан 477 хүн/цаг сургалтыг орсон байна. 2024 онд уурхайд 3 сараас дээш хугацаагаар уурхай дээр ирээгүй болон шинэ ажилтнуудад сургалтыг орсон юм. Энэхүү сургалтуудын агуулгад уурхайн байгаль орчны үйл ажиллагаа, усны хэмнэлт зөв зохистой хэрэглээ, цөлжилт, асгаралт, хог хаягдал болон ажилчдын зүгээс үзүүлж болохуйц сөрөг нөлөөлөл түүнээс хэрхэн сэргийлэх талаарх байгаль орчны бүх талын мэдээллийг нэгтгэсэн агуулга бүхий байдаг. 2024 оны 10 -р сарын 15-ны байдлаар сургалтад суусан хүмүүсийн мэдээллийг дараах графикт харуулав.




График 16. Байгаль орчны сургалтад хамрагдсан байдал



Зураг 64. Ажилчидад БО-ны талаарх сургалтыг орж буй нь

12.3 Уурхайн хэмжээнд стандартын бус нүхэн жорлонг халж эко стандартын дагуу соруулдаг нүхэн жорлон болгох

2023 онд хөрс, агаарын бохирдол ихээр үүсгэгч уурхайн хэмжээнд зориулатын бус 7 нүхэн жорлон байсанг буулгаж стандартад нийцсэн соруулдаг Эко модон жорлонгоор сольж байсан юм. 2024 онд зориулалтын бус 3 нүхэн жорлон байсанг стандартад нийцсэн соруулдаг Эко модон жорлонгоор сольж уурхайн хэмжээнд ашиглагдаж буй бүх нүхэн жорлон хөрсрүү нэвчилт өгөхгүй стандартад нийцсэн нүхэн жорлонтой болсон юм.



Зураг 65. Хөрс орчны бохирдол үүсгэсэн стандартын бус нүхэн жорлогийн оронд Эко соруулдаг 00 болгон өөрчиллөө

12.4 Усны мониторингийн цооногийг нэмэх хашаа , хаягжуулалт хийх

Биологийн нөхөн сэргээлтийн талбай явах зам дагуу усны хайгуул хийгээд үлдсэн байсан цооногийн хашаалж хамгаалалтанд авч усны мониторингийн хяналтын цооног болгож ашиглаж сар бүр усны түвшний хэмжилтийг хийж ажиллаж байгаа юм. Газарзүйн байрлалын хувь усны хяналтын цооног болгох бүрэн боломтой гэж үзсэн юм.




Зураг 66. Хяналтын цооногт усны түвшинд хэмжилт хийж буй нь

12.5 Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих

Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд Ноён сумын нутаг Ганзагат багийн Цоохондойд 5 га талбайд загийн ойжуулалтын ажлыг хийлээ. Заг тарих ажлыг “Галбын Ойжуулалт” ХХК-аар гүйцэтгүүлэв. 5 га талбайд 6 орчим мянга 2 настай загийг тариалав. Мөн Ноён суманд 5 га талбайд 2500 гаруй хайлаас модыг намрын тарилтаар хийж гүйцэтгэв.



Зураг 67. Ноён сумын газрын даамал, Байгаль хамгаалагч, компаний төлөөлөл заг тариалах боломжтой талбайнуудаар явж үзэв



Зураг 68. Заг тариалах талбайг сонгож, заг тариалах талбай оролцоох хүдгийг үзэж буй нь

“Галбийн ойжуулалт” ХХК-ийн ажилчид 06 дугаар сарын 13-ны өдөр Ноён сумын газрын даамал, байгаль хамгаалагч, “Энхтунх Орчлон” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн нартай хамтран заг тариалах талбайг сонгосон юм. Түүний загийн ойжуулалтын ажлыг 6 дугаар сарын 28-ний өдрөөс эхлэн хийж эхлэв.



Зураг 69. Гүйцэтгэгч компаний ажилчид загийн ойжуулалт хийхээр кемпээ барьж буудалласан байдал



Зураг 70. Терра энерджи ХХК-ын БО-ны мэргэжилтэнгүүд модны нүхээ ухаж буй үед нь ажлын талбайтай танилцаж буй байдал



Зураг 71. Бортгогтой загийг талбайд суулгахаар бэлгэсэн байдал



Зураг 72. Талбайд заг суулгаж буй байдал

Тус компани ойжуулалтын ажлыг 16 хоногийн хугацаанд гүйцэтгэсэн юм. Тус компани ойжуулалтын усалгаа, арчилгааг 3 жилийн хугацаанд бүрэн хариуцаж ажиллах бөгөөд Цагаан Өвөлжөө ХХК нь хяналт тавих маягаар ажиллах юм.



Зураг 73. Ойжуулалтын ажил дуусаад 1 сарын дараа БО-ны мэргэжилтэнүүд талбайд хяналт хийжэ буй нь



Зураг 74. Ойжуулалт ажлыг хийснээс 2 сарын дараах ургалтын нөхцөл байдал



Зураг 75. Ойжуулалт ажлыг хийснээс 2 сарын дараах ургалтын нөхцөл байдал



Зураг 76. Заг тариалсан талбайн ерөнхий харагдах байдал



Зураг 77. Ноён суманд мод тариалсан талбайн ерөнхий харагдах байдал

12.6 Байгаль орчны аудитыг мэргэжлийн компаниаар гүйцэтгүүлэх

Байгаль орчны Аудитыг мэргэжлийн компани болох “Энвайроментал Комплајц” ХХК-аар гүйцэтгүүлэв.



Зураг 78. Байгаль орчны аудитын тайлангийн нүүр болон дүгнэлтийн хуудас

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 28. Байгаль орчны хэрэгжилт оршин суугчид танилцуулах

№	БОХТ-ны биелэлтийг оролцогч талуудад тайлагнах, хэрэгжүүлэх хуваарь	Тайлагнах хэлбэр	Зохион байгуулах газар	Хариуцагч	Биелэлт
1	БОМТ-ны хэрэгжилтын явц танилцуулах	Хагас жил	Тайлан хүргүүлэх	3-р улирал	Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хагас жилийн биелэлтийн тайланг Ноён сумын байгаль хамгаалагчид 07 дугаар сарын 10-ний дотор хүргүүлж батлуулсан юм. Хагас жилийн ажлын тайлангийн баталсан нүүрийг тайлангийн хавсаргалтанд оруулав.
3	Төслийн нөлөөллийн бүсийн зарим иргэдэд байгаль орчны ажлын явцыг танилцуулна	Төлөвлөгөө болон төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулах	Уурхай болон иргэд нийтийн цуглаан	Удирдлага, Байгаль орчин, Орон нутаг	Ноён сумын иргэдийн болон нөлөөллийн бүсийн төлөөлөл болох ахмадууд уурхай, байгаль орчин, нөхөн сэргээлийн ажилтай танилцахаар 2024 оны 5-р сард ирсэн. Мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжилтийн талаар танилцуулага мэдээллийг 3-р сард Ноён суманд танилцуулав. Дэлгэрэнгүйг 13.1 дэд бүлэгт.
4	Байгаль орчны мэдээнүүдийг нэгтгэж БОХУБ, байгаль хамгаалагчид хүргүүлэх	Хог хаягдалын мэдээ, ус ашиглалтын тайлан	Байгаль хамгаалагч	Байгаль орчин	Байгаль орчны үйл ажиллагаатай холбоотой сар бүрийн хог хаягдал, ус ашиглалтын тайланг Ноён сумын байгаль хамгаалагчид хүргүүлж тайлагнаж батлуулж ажилласан. Хог хаягдлын мэдээ болон ус ашиглалтын сар бүрийн батлагдсан тайланг хавсаргалтад оруулав.

13.1 Төслийн нөлөөллийн бүсийн зарим иргэдэд байгаль орчны ажлын явцыг танилцуулна

Ноён сумын иргэдийн болон нөлөөллийн бүсийн төлөөлөл болох ахмадууд уурхай, байгаль орчин, нөхөн сэргээлтийн ажилтай танилцахаар 2024 оны 5-р сард ирсэн. Уурхайд ирсэн ахмадуудын ил уурхай, биологийн нөхөн сэргээлтийн талбай, техникийн нөхөн сэргээлтийн талбай, уурхайн ногоон байгууламж, уурхай оффис дээр сургалт мэдээллүүдийг өгсөн юм.



Зураг 79. Нөлөөллийн бүсийн иргэд уурхайн үйл ажиллагаатай танилцав



Зураг 80. Байгаль орчны мэргэжилтэн Б.Ихбаяр төлөвлөгөө болон уурхайн танилцуулага хийж буй нь

ХАВСРАЛТ

1. Уурхайн ерөнхий план
2. 2024 оны уурхайн эвдрэлд өртсөн газрын мэдээлэл
3. 2024 оны ус ашигалтын сар бүрийн тайлан
4. Усны төлбөр төлсөн баримт
5. Агаарын шинжилгээг хөндлөнгийн байгуулгаар хийлгэсэн лабораторийн тайлан
6. Улирал бүрийн усны шинжилгээний хариу
7. Улирал бүрийн хөрсний шинжилгээний хариу
8. Орон нутагруу тээврийн хэрэгсэлээр зорчих хөдөлгөөн хийж зааварчилгаа авсан ажилчидын бүртгэл
9. Хаягдал тос хүлээлгэн өгсөн баримтууд
10. Тэрбум хөтөлбөрийн хүрээнд тарьсан Галбийн Ойжуулат ХХК ажлын явцын тайлан
11. “Спейшил Майнинг Сервис” ХХК – ийн сар бүрийн тэсэлгээний агуулахын ажлын байрны үзлэг
12. Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр төлсөн баримт
13. Мод, дугуй хүлээлгэн өгсөн акт
14. БОМТ-ний хагас жилийн тайлангийн батлагдсан нүүр
15. Орон нутагруу хог хаягдал тээвэрлэсэн бүртгэл мэдээлэл
16. Ажлын байрны үзлэгийн хуудас